



Тайланг бэлтгэсэн:

Үндэсний аудитын
газрын Гүйцэтгэлийн
аудитын газар

Газрын захирал бөгөөд
Тэргүүлэх аудитор

М.Давааням

Аудитын менежер

З.Ариунзаяа

Ахлах аудитор

Д.Гандолгор

Аудитор

Ц.Цолмон

Э.Уянга

Г.Бямбаа

Ж.Ганчимэг

Уг тайланг YAG-ын
www.audit.mn
цахим хуудаснаас үзнэ
үү.

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах зүйл байвал
263755 дугаарын утас,
323266 дугаарын
факсаар харилцана уу.

ХАЯГ:

Үндэсний аудитын газар
Засгийн газрын 4 дүгээр
байр, Бага тойруу-6,
Улаанбаатар-15160,
Монгол Улс

2018 оны 3 дугаар сар

Агуулга

Товчилсон үгийн тайлбар	2
Хүснэгт, графикийн товъёог	2
Аудит хийсэн үндэслэл	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ	3
Аудитын арга зүй	3
Аудитын шалгуур үзүүлэлт, хугацаа	3
Ерөнхий мэдээлэл	4
БҮЛЭГ 1. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого, зохицуулалт тогтворгүй, харилцан уялдаагүй, үр дүн хангалтгүй байна	8
Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн зохицуулалтууд тогтворгүй, харилцан уялдаагүй байгаа нь дэвшүүлсэн бодлогын үр дүн хангалтгүй байх шалтгаан болж байна	8
Татвараас чөлөөлөгдөх барааг тодорхойлж өгөөгүйгээс импортолсон зарим барааны чөлөөлөлт төрөөс баримтлах бодлоготой нийцэхгүй байна	8
Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хуулиудад хууль, тогтоомжийг боловсруулах, батлуулахад баримтлах шаардлагыг мөрдөөгүй байна	9
Татвараас чөлөөлөх тусгайлсан хуулиудыг төсвийн жилийн дундуур баталж байгаа нь төсвийн орлогыг төлөвлөсөн хэмжээгээр бүрдүүлэхэд хүндрэл учруулж байна	10
Хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэрэгжиж дуусах хугацааг цаг үеийн хэрэгцээ шаардлагатай уялдуулаагүйгээс 0.4 тэрбум төгрөгийн төсвийн орлого бүрдүүлэх боломжийг алдсан байна	11
Засгийн газраас баталсан татвараас чөлөөлөх барааны жагсаалт хуулийн зорилгыг алдагдуулж салбарын үйлдвэрлэлийг бус, салбарын хэрэглээг дэмжсэн байна	11
Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэрэгжилт, үр дүнд тооцоо судалгаа хийж, үнэлэлт дүгнэлт өгдөг байгууллага байхгүй байна	12
Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслийн барааг түр горимд байршуулах хугацааг хуульд уян хатан тусгах шаардлагатай байна	12
Монгол Улс олон улсын жишгээс илүү, хавтгайруулсан байдлаар хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлж байна	12
БҮЛЭГ 2. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд тавих хяналтын тогтолцоо үр нөлөөгүй байна	14
Татварын чөлөөлөлтөнд тавих дотоод хяналт үр нөлөөгүй байна	14
Гаалийн байгууллага татварын чөлөөлөлтөд хамрагдсан бараанд гаалийн бүрдүүлэлтийн дараах хяналт шалгалт хийх чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлж иржээ	15
Татварын байгууллагын татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд тавих хяналтын үр нөлөө хангалтгүй байна	16
Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн мэдээ, тайлангийн уялдааг хангуулаагүй, олон нийтэд мэдээллийг ил тод хүргүүлээгүй байна	17
ДҮГНЭЛТ	19
ЗӨВЛӨМЖ	20
Холбогдох байгууллагын санал	21
Ирүүлсэн саналд өгөх тайлбар	26
Хавсралт	27
Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаал	29



Товчилсон үгийн тайлбар

ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ААН	Аж ахуйн нэгж
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ЗСБНХУ	Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс
ОАТ	Онцгой албан татвар
ОХУ	Оросын Холбооны Улс
ХАА	Хөдөө аж ахуй
ХХААХУ	Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
УБГГ	Улаанбаатар гаалийн газар
УИХ	Улсын Их Хурал
УТОХГ	Улсын төсвийн орлого хяналтын газар
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
МУИС	Монгол Улсын Их Сургууль
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
ТОГ	Татвар орлогын газар
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
тбм.төг	Тэрбум төгрөг
тн	Тонн
ШУТИС	Шинжлэх ухаан технологийн их сургууль
CAIS	Customs Administration Information System (Гаалийн удирдлагын мэдээллийн систем)

Хүснэгт, графикийн товъёог

Хүснэгт №1	Бодлогын баримт бичгийн зорилтуудыг татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн зохицуулалттай харьцуулсан байдал	4-5
Хүснэгт №2	Хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдсан хуулиуд, заалтын тоо	6
Хүснэгт №3	Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэмжээ	6
Хүснэгт №4	Татварын хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой хуулийн өөрчлөлтийн судалгаа	9-10
Хүснэгт №5	Татвараас чөлөөлөгдсөн барааны хөнгөлөлтийн кодыг хооронд зөрүүлж бүртгэсэн жагсаалт	14
График №1	Татварын орлогод хөнгөлөлт, чөлөөлөлтийн эзлэх хувь	7
График №2	Нэгдсэн төсвийн алдагдалд татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн эзлэх хувь	7
График №3	Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт /салбараар/	7
График №4	Онцгой албан татвар ногдсон болон онцгой албан татвараас чөлөөлөгдсөн автомашины тоо	11



Аудит хийсэн үндэслэл

Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2017 оны 2 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2017 оны А/12 дугаар тушаалаар баталсан ҮАГ-ын аудитын ажлын төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт, хамарсан хүрээ

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого, түүний хэрэгжилт, үр дүнг шалгаж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтан болон УИХ-д танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаарх бодлого, зохицуулалт үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх;
- Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд тавих хяналтын тогтолцоо үр нөлөөтэй эсэх

Аудитад ААНОАТ-ын тухай, НӨАТ-ын тухай, ОАТ-ын тухай, ХХОАТ-ын тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, НӨАТ-аас болон Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн хэрэгжилтийг Сангийн яам, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, эдгээрийн харьяа газар, хэлтэс болон зарим яамд, байгууллагын 2015, 2016 оны үйл ажиллагааг хамруулан, түүврийн аргаар шалгав.

Хөнгөлөлт, чөлөөлөлтийг зохицуулсан бусад хууль, тогтоомжуудын аудитын дүн, дүгнэлтэд үзүүлэх нөлөөлөл нь материаллаг бус бөгөөд холбогдох мэдээллийг боловсруулах, судалгаа хийхэд өртөг, өгөөжийн хувьд харьцангуй үр ашиг багатай гэж үзсэн тул аудитад хамруулан авч үзээгүй болно.

Аудитын арга зүй

Аудитад Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журам болон гүйцэтгэлийн аудитын удирдамж /АДБОУС 3000-3100/-ийг ашиглаж, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Ингэхдээ татварын хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой хууль, эрхийн актыг судлах, татварыг хөнгөлж, чөлөөлсөн мэдээ, судалгаанд дүн шинжилгээ хийх, холбогдох байгууллагын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах, гаалийн байгууллагын CAIS програмыг ашиглан мэдээлэл боловсруулан түүвэрчлэх зэрэг аудитын аргуудыг ашиглав.

Аудитын шалгуур үзүүлэлт, хугацаа

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Монгол Улсын мянганы хөгжлийн зорилгод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого;
- Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030;
- Засгийн газрын 2012-2016, 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр;
- Татварын Ерөнхий хууль;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль;
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль;
- Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиуд;
- Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль;
- Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиуд;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Онцгой албан татварын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төрийн аудитын тухай хууль;
- Дээрх хуулиудтай нийцүүлэн гаргасан дүрэм, журам, бусад эрх зүйн актууд

Аудитыг ҮАГ-ын ГАГ-ын захирал бөгөөд Тэргүүлэх аудитор М.Давааням, аудитын менежер З.Ариунзаяа нар хянан удирдаж, тус газрын ахлах аудитор Д.Гандолгор, аудитор Ц.Цолмон, Э.Уянга, Г.Бямбаа, Ж.Ганчимэг нар 2017 оны 8 дугаар сарын 07-ны өдрөөс 12 дугаар сарын 15-ны өдрүүдэд хийж гүйцэтгэв.



Ерөнхий мэдээлэл

Татвар нь санхүүгийн буюу төсвийн орлого бүрдүүлэх, зохицуулалтын буюу нийгэм, эдийн засгийн асуудлыг шийдвэрлэх гэсэн үндсэн 2 үүрэгтэй бөгөөд Монгол Улсад татварын санхүүгийн үүрэг нь төсвийн орлогыг нэмэгдүүлэхийн тулд татварын бааз суурийг тэлэх бодлогоор илэрч байгаа бол, зохицуулалтын үүрэг нь нийгмийн хөгжил, эдийн засгийн тогтвортой байдлыг хангахын тулд үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, татвар ногдуулах орлогын босгыг өндөрсгөх, татварын хувь хэмжээ болон хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх торгууль, хүүгийн хэмжээг бууруулах зэрэг татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогоор илэрч байна. Тухайлбал,

- ААНОАТ-ын тухай хуулиар татвар ногдуулах орлогын босго 0-100.0 сая төгрөг байсныг 0-3.0 тэрбум төгрөг болгон өндөрсгөж, татварын хувь хэмжээг 10, 25 хувь, ХХОАТ-ын тухай хуулиар татварын хувь хэмжээ 10, 20, 30 хувийн шатлалтай байсныг 10 хувь, НӨАТ-ын тухай хуулиар татварын хувь хэмжээ 15 хувь байсныг 10 хувь болгон тус тус бууруулсан;
- УИХ-аас 2015 онд баталсан НӨАТ-ын тухай хуулиар /шинэчлэн найруулсан/ албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх босгыг 10.0 сая төгрөг байсныг 50.0 сая төгрөг болгон өндөрсгөсөн;
- Мөн УИХ-аас 2017 оны 2 дугаар сард баталсан ААНОАТ-ын тухай хуулиар /шинэчлэн найруулсан/ ЖДҮ-ийг дэмжих зорилгоор жилийн 1.5 тэрбум төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжид 1 хувийн татвар ногдуулахаар хуульчилсан;
- Татварын хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг зөөлрүүлж, торгуулийн хэмжээ 50 хувь байсныг 30 хувь, хүүгийн хэмжээ хоног тутамд 0.5 хувь байсныг 0.1 хувь болгосон;
- Иргэд, аж ахуй нэгжид нуусан эд хөрөнгөө нэг удаа ил тод, үнэн зөв тайлагнаж, бүртгүүлэх боломжийг олгох зорилгоор Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийг 2015 онд хэрэгжүүлсэн;

УИХ-аас 2008 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Үндэсний хөгжлийн цогц бодлого 2008-2021”, 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” зэрэг төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, Засгийн газрын мөрийн хөтөлбөрт дэвшүүлсэн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаарх зорилтууд нь ААНОАТ, НӨАТ, ХХОАТ хуулиудын татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг зохицуулсан заалтуудтай харилцан уялдаатай байна.

Хүснэгт 1. Бодлогын баримт бичгийн зорилтуудыг татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн зохицуулалттай харьцуулсан байдал

д/д	Бодлогын баримт бичгийн зорилт	Хуулийн нэр, заалт
1	Хувийн хэвшил тэргүүлсэн эдийн засгийн өндөр өсөлтийг тогтвортой хадгалах, өсөлтийн үр дүнд дундаж давхаргын эзлэх хувийг нэмэгдүүлэх, хүний хөгжил, боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухаан, технологи, байгаль орчны тогтвортой хөгжлийг тэргүүлэх чиглэл болгож, нийгмийн орлого багатай дундаж болон эмзэг давхаргын амьдралын доод түвшинг /орон сууц, сурах, хөдөлмөр эрхлэлт гэх мэт/ хангах, орлогын ялгаварт байдлыг багасгах зорилтын хүрээнд хувь хүний болон аж ахуй эрхлэлтийн зарим орлогын төрөл болон бараа, үйлчилгээг татвараас хөнгөлж, чөлөөлөх, зорилтот бүлэгт чиглэсэн нийгмийн халамж, дэмжлэгийг хэрэгжүүлэх	ААНОАТ-ын тухай хуулийн: - 19.1-т үр тариа, төмс, хүнсний ногоо, сүү, жимс жимсгэнэ, тэжээлийн ургамлыг дотооддоо үйлдвэрлэсэн буюу тариалан орлогод ногдох татварыг 50 хувь хөнгөлөх; - 19.12-т аймаг, сумын төв нь Улаанбаатар хотоос 550 км-ээс хол байршилтай аймаг, суманд байнгын үйл ажиллагаа явуулдаг, бүртгэлтэй, орон нутгийн төсөвтэй харьцдаг албан татвар төлөгчийн орлогын албан татварыг 550 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 50 хувь, 1000 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 90 хувь хөнгөлөх; - 19.14-т жилийн татвар ногдох орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй, газар тариалан, мал аж ахуй, хүнс, барилга, нэхмэлийн болон хувцас үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулдаг татвар төлөгчийн зөвхөн тухайн салбарт явуулсан үйл ажиллагаанаас олсон орлогод ногдох татварыг 90 хувь хөнгөлөх; - 18.1.6-д жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг дотооддоо үйлдвэрлэх, үйлдвэрлэн борлуулах үйл ажиллагаанаас олсон орлогыг чөлөөлөх; - 18.1.8-д байгалийн нөөцийг хэмнэлттэй ашиглах, орчны бохирдол, хаягдлыг багасгах, байгальд халгүй техник, тоног төхөөрөмжийг борлуулсан орлогыг чөлөөлөх; - 18.1.9-д ... дотоодод шинээр үйлдвэрлэсэн инновацийн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогыг чөлөөлөх; НӨАТ-ын тухай хуулийн: - 13.1.15-д газар тариалан эрхлэгчийн дотооддоо тарьж борлуулсан үр тариа, төмс, хүнсний ногоо, суулгац, жимс жимсгэнэ, үйлдвэрлэсэн гурил; - 13.1.16-д Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрийн аргаар төхөөрч бэлтгэн дотооддоо борлуулсан тураг болон шулж ангилсан мах, боловсруулаагүй дотор эрхтэн, дайвар бүтээгдэхүүн; - 13.1.17-д Монгол Улсын нутаг дэвсгэрт дотоодын түүхий эдээр боловсруулан дотооддоо борлуулсан хүнсний сүү, сүүн бүтээгдэхүүн; - 13.1.18-д Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн, үйлдвэрлэн борлуулсан жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл; - 13.1.21-т экспортод гаргасан түүхий болон угаасан, самнасан ноолуур, арьс шир; - 13.1.27-д чөлөөт бүсэд худалдаж авсан 3.0 сая төгрөг хүртэл үнийн дүнтэй барааг тус тус чөлөөлөх;



		ХХОАТ-ын тухай хуулийн: - 16.1.13-т малчин өрх, мал бүхий этгээдийн зөвхөн малын тоо толгойд ногдох орлогыг чөлөөлөх; - 16.1.14-т Монгол Улсын нутаг дэвсгэрт ЖДҮ-ийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл үйлдвэрлэх, үйлдвэрлэн борлуулах үйл ажиллагаанаас олсон орлогыг чөлөөлөх; - 24.1-т цалин хөлс, түүнтэй адилтгах орлогод ногдох жилийн албан татварт 84,000 төгрөгийн татварын хөнгөлөлт; - 24.5-д Монгол Улсад оршин суугч хувь хүний үр тариа, төмс, хүнсний ногоо, сүү, жимс жимсгэнэ, тэжээлийн ургамлын үйлдвэрлэлээс олсон орлогод ногдуулах татварт 50 хувь хөнгөлөлт; - 24.6-д татвар төлөгчийн төрсөн буюу үрчилсэн хүүхэд гадаад, дотоодын их, дээд болон мэргэжлийн боловсролын сургууль, коллежид элсэн суралцаж байгаа бол түүний сургалтад төлсөн, баримтаар нотлогдож байгаа төлбөрийн хэмжээгээр татварын хөнгөлөлт; - 24.7-д суралцаж байх хугацаандаа хөдөлмөр эрхлэлтийн орлогоосоо татвар төлж, улмаар сургалтын төлбөр төлсөн их, дээд болон мэргэжлийн боловсролын сургууль, коллежид суралцагчийг энэ хуулийн 24.6-д заасан хөнгөлөлт; Онцгой албан татварын тухай хуулийн: - 7.1.2-т гэрийн нөхцөлд энгийн аргаар өөрийн хэрэгцээнд зориулж сүү, сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архи; - 7.1.4-т гаалийн байгууллагаас зорчигчдын хувийн хэрэгцээнд зориулж татваргүй нэвтрүүлэхийг зөвшөөрсөн хэмжээний архи, тамхийг татвараас чөлөөлөх;
2	Мөнгөний болон санхүү, татварын харилцан уялдаатай бодлогоор хуримтлалыг бий болгон хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хувьцааны ногдол ашиг, хүүгийн орлого, санхүү даатгалын үйл ажиллагааг хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах	ААНОАТ-ын тухай хуулийн: - 18.1.1-т Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргын болон Монгол Улсын Хөгжлийн банкны өрийн бичгийн /бонд/ хүүгийн орлого; - 18.1.3-т гишүүдийнхээ бүтээгдэхүүнийг худалдах үйл ажиллагааны зуучлалын үнийн зөрүүгээс олсон хоршооны орлого; - 18.1.7-д зээлийн батлан даалтын байгууллагын хуульд заасан үндсэн үйл ажиллагаанаасаа олсон орлого; - 18.1.10-т хадгаламжийн даатгалын сангийн хураамжийн орлого; - 18.1.11-д хөрөнгө оруулалтын сангийн орлого; - 18.1.15-д ирээдүйн өв санд улсын төсвөөс хуваарилсан орлого, сангийн хөрөнгө оруулалтын орлогыг тус тус чөлөөлөх; НӨАТ-ын тухай хуулийн: - 13.5.1-т валют солих үйлчилгээ; - 13.5.2-т мөнгө хүлээн авах, шилжүүлэх, баталгаа, төлбөрийн нэхэмжлэл гаргах, вексель, хадгаламжийн данстай холбогдсон банкны үйлчилгээ; - 13.5.3-т даатгал, даатгалын зуучлал, давхар даатгал, эд хөрөнгийн бүртгэлийн үйлчилгээ; - 13.5.4-т үнэт цаас, хувьцаа гаргах, шилжүүлэх, борлуулах, хүлээн авах, тэдгээрт баталгаа гаргах үйлчилгээ; - 13.5.5-д зээл олгох үйлчилгээ; - 13.5.6-д нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг байршуулсны хүүг олгох, шилжүүлэх үйлчилгээ; - 13.5.7-д банкны болон банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршооны зээлийн хүү, санхүүгийн түрээсийн хүү, ногдол ашиг, зээлийн баталгааны хураамж, даатгалын гэрээний хураамж төлөх үйлчилгээг тус тус чөлөөлөх; ХХОАТ-ын тухай хуулийн: - 16.1.5-д Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргын болон Монгол Улсын Хөгжлийн банкны өрийн бичиг /бонд/-ийн төлбөр, хүү, анзын орлогыг чөлөөлөхөөр тус тус заасан байна.

Бодлогын баримт бичгүүдэд дэвшүүлсэн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн зорилтуудыг хэрэгжүүлснээр дараах эерэг, сөрөг үр дүн бий болжээ. Үүнд:

Эерэг үр дүн

- 2012-2016 оны байдлаар аж ахуй нэгжийн тоо нэмэгдэж, татварын бааз суурь өргөжсөн. Тухайлбал,
- ААНОАТ төлөгч аж ахуйн нэгжийн тоо 82,479-өөс 121,209 болж 1.5 дахин өсч, үүнээс тайлангаа ирүүлсэн татвар төлөгчдийн тоо 69,453-88,258 болж нэмэгдсэн;
- Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 33.8 их наяд төгрөгийн хөрөнгө, орлого ил болж татварын бааз суурь өргөжсөн;

Сөрөг үр дүн

- Хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэрэгжиж дуусах хугацааг цаг үеийн хэрэгцээ шаардлагатай уялдуулаагүй, төсвийн жилийн дундуур татвараас чөлөөлөх хуулийг баталснаар татварын орлого төлөвлөсөн хэмжээнээс дутуу төвлөрч, мөн зарим хуульд татварын чөлөөлөлтөд хамрагдах барааны жагсаалтыг Засгийн газраас батлах талаар заагаагүйгээс тухайн хуулийн хүрээнд импортолсон зарим бараа төрөөс баримтлах бодлоготой зөрчилдөж байгаа зэргээс шалтгаалан зөвхөн 2016 онд 63.8 тэрбум төгрөгийн татвар хураах боломж алдагдсан;
- Зарим татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн заалт хэт ерөнхий, ойлгомжгүй, утга санаа давхацсанаас тооцоолол хийх, хяналт тавихад хүндрэл үүсэх болсон;
- НӨАТ төлөх борлуулалтын орлогын доод хэмжээг 2015 онд батлагдсан НӨАТ-ын тухай хуулийн шинэчилсэн найруулгад 50.0 сая төгрөг болгож өсгөснөөс шалтгаалж 2016 онд НӨАТ-ын тайлан гаргагчдын тоо 26,563 болж, өмнөх оноос 1,114 ААН-ээр буурсан.
- ААНОАТ төлөгчдийн тоо хэдийгээр нэмэгдсэн ч "Х" болон алдагдалтай тайлан гаргасан ААН-ийн тоо 36,688-55,178 болж өссөн сөрөг үр дүн гарчээ.

2016 оны жилийн эцсийн байдлаар нийт 15 хуульд тусгагдсан зохицуулалтаар татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх 248 заалт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бөгөөд тэдгээрээс 57 заалт нь НӨАТ-



ын тухай, 42 заалт нь Гаалийн тариф, гаалийн татварын тухай, 35 заалт нь Улсын тэмдэгтийн хураамжийн тухай, 25 заалт нь ААНОАТ болон ХХОАТ-ын тухай хуулийн заалт эзэлж байна.

Хүснэгт №2. Хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдсан хуулиуд /заалтын тоо/

д/д	Хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдсан хуулиуд	Чөлөөлөлт	Хөнгөлөлт	Нийт хөнгөлөлт, чөлөөлөлт
1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай	16	9	25
2	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай	47	0	47
3	Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай	10	0	10
4	Гаалийн тариф, гаалийн татварын тухай	17	0	17
5	Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай	25	0	25
6	Хувь хүний орлогын албан татварын тухай	18	7	25
7	Онцгой албан татварын тухай	12	0	12
8	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай	11	7	18
9	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай	32	3	35
10	Газрын төлбөрийн тухай	13	0	13
11	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай	4	3	7
12	Агаарын бохирдлын төлбөрийн тухай	4	1	5
13	Ус бохирдуулсны төлбөрийн тухай	3	1	4
14	Чөлөөт бүсийн тухай	1	2	3
15	Бууны албан татварын тухай	2	0	2
	Нийт	215	33	248

Эх сурвалж: Сангийн яамны төсвийн гүйцэтгэл

2016 онд татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн чиглэлээр гарсан хуулийн заалтуудыг зориулалтаар нь ангилж үзвэл нийгмийн халамж, иргэдийн хэрэглээг дэмжих чиглэлээр 72, хүний эрх, хүний хөгжлийг хангах чиглэлээр 54, дэд бүтцийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах чиглэлээр 53 зэрэг нийт 179 заалтад 309.7 тэрбум төгрөгийн¹ хөнгөлөлт, чөлөөлөлт олгогдсон бол санхүүгийн болон уул уурхайн салбарт хамаарах 69 заалттай холбогдуулан 598.6 тэрбум төгрөгийн хөнгөлөлт, чөлөөлөлт олгожээ.

Үүнээс үзэхэд санхүүгийн болон уул уурхайн салбарт хамаарах хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого, арга хэмжээний тоо бага боловч үзүүлсэн эдийн засгийн өгөөж нь бусад салбартай харьцуулахад бараг 2 дахин өндөр байна.

2015 онд холбогдох хууль тогтоомжийн дагуу татвар төлөгчдөд үзүүлсэн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт 656.8 тэрбум төгрөг байсан бол 2016 онд энэ нь 1.4 дахин өсөж, 908.3 тэрбум төгрөгт хүрчээ.

Аудитад хамруулан авч үзсэн татварын хууль, тогтоомжийн хүрээнд татвар төлөгчдөд эдлүүлсэн хөнгөлөлт, чөлөөлөлтийн дүнг хөнгөлөлт, чөлөөлөлтийг зохицуулсан хууль, тогтоомжуудаар ангилан үзэхэд НӨАТ-ын хуулиар хөнгөлөгдөж, чөлөөлөгдсөн татварын нийт дүн нь татварын орлогын 6.1-5.1 хувьтай тэнцэж иржээ.

Хүснэгт №3. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/

№	Үзүүлэлт	2016 он		2015 он	
		Хэмжээ	хувь	Хэмжээ	хувь
1	ААНОАТ-ын тухай хууль	296.6	32.7	59.1	9
2	НӨАТ-ын тухай хууль, НӨАТ-аас чөлөөлөх тухай хууль	251	27.6	313.3	47.7
3	Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль	45.7	5	47.2	7.2
4	ХХОАТ-ын тухай хууль	121.3	13.4	102.7	15.6
5	Онцгой албан татварын тухай хууль	193.7	21.3	134.5	20.5
	Нийт хөнгөлөлт, чөлөөлөлтийн дүн	908.3	100	656.8	100
6	Татварын орлого	4,951.00	-	5,119.00	-

Эх сурвалж: Сангийн яамны төсвийн гүйцэтгэл


Дээрх хүснэгтээс харахад ААНОАТ-ын тухай хуулийн хүрээнд үзүүлсэн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэмжээ 2016 онд 237.5 тэрбум төгрөг буюу 23.7 хувиар огцом өссөн нь давхар татварын гэрээний нөхцөлийн дагуу аж ахуйн нэгжүүдэд үзүүлсэн 190.0 тэрбум төгрөгийн /үүнээс 76 хувь буюу 144.3 тэрбум төгрөг Оюутолгой ХХК/ хөнгөлөлтийг ААНОАТ-ын тайланд тусгасантай холбоотой байна.

¹ Хөнгөлөлт чөлөөлөлтийн дээрх дүнд Байгалийн нөөц ашигласны төлбөр, Улсын тэмдэгтийн хураамж, Газрын төлбөр, Агаарын бохирдлын төлбөр, Ус бохирдуулсны төлбөр, Чөлөөт бүсийн тухай болон Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, Бууны албан татварын тухай хуулиудыг хамруулан тооцоогүй болно.




Татварын орлого ба хөнгөлөлт, чөлөөлөлтийн харьцааг сүүлийн 7 жилийн байдлаар харуулбал,

График №1 Татварын орлогод хөнгөлөлт, чөлөөлөлтийн эзлэх хувь



Эх сурвалж: Сангийн яамны төсвийн гүйцэтгэл

График №2 Нэгдсэн төсвийн алдагдалд татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн эзлэх хувь /тбм.төг/




Эх сурвалж: Сангийн яамны төсвийн гүйцэтгэл

Нэгдсэн төсвийн алдагдал, хөнгөлөлт, чөлөөлөлт нь хоорондоо төгс эерэг хамааралтай байдаг боловч сүүлийн 2 жилийн байдлаар татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн дүн 38 хувиар өссөн байхад төсвийн алдагдлын хэмжээ жилд 216 хүртэл хувиар нэмэгдсэн байгаа нь хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлсний улмаас алдагдсан татварын орлого нь төсвийн алдагдлын шууд шалтгаан биш болох нь харагдаж байна.

2016 оны байдлаар татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн 49 хувь буюу 422.4 тэрбум төгрөг банк, санхүү, даатгалын салбарт, 22 хувь буюу 192.2 тэрбум төгрөг бөөний болон жижиглэн худалдаа эрхлэгчдэд, 7 хувь буюу 65.3 тэрбум төгрөг уул уурхайн олборлолт, боловсруулах үйлдвэрлэл, цахилгаан хийн салбарт, 6 хувь буюу 50.5 тэрбум төгрөг эрүүл мэнд, нийгмийн халамжийн салбарт, 16 хувь буюу 177.9 тэрбум төгрөг бусад салбарт тус тус ногдож байна.

График №3 Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт /салбараар/



Эх сурвалж: Сангийн яамны төсвийн гүйцэтгэл

Дээрх графикаас харахад банк, санхүүгийн салбарт үзүүлсэн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэмжээ хамгийн их байгаа боловч банкны зээлийн хүүгийн дундаж түвшин 19.5 хувиас² буухгүй байгаа нь тус салбарын нийгэм эдийн засагт үзүүлж байгаа үр нөлөө бага байгааг харуулж байна.

² Монгол банкны статистик мэдээнээс авав.



БҮЛЭГ 1. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого, зохицуулалт тогтворгүй, харилцан уялдаагүй, үр дүн хангалтгүй байна

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн зохицуулалтууд тогтворгүй, харилцан уялдаагүй байгаа нь дэвшүүлсэн бодлогын үр дүн хангалтгүй байх шалтгаан болж байна

1.1. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар дэвшүүлсэн бодлогыг хэрэгжүүлэх явцад холбогдох зохицуулалтуудыг олон удаа өөрчилж, шинэчилж иржээ. Тухайлбал,

- 1.1.1. 2005 онд Оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зориулалтаар импортолж байгаа сэлбэг, түүхий эд, үндсэн болон туслах материалыг гаалийн татвар болон НӨАТ-аас чөлөөлөх тухай хуулиуд батлагдан, хэрэгжиж байсан боловч НӨАТ-аас чөлөөлөх тухай хуулийг 2015 оны 7 дугаар сард хүчингүй болгосон;
- 1.1.2. 2008 онд Импортоор оруулж байгаа болон дотооддоо худалдан борлуулсан хөдөө аж ахуйн зориулалттай шинэ трактор, комбайн, машин механизм, гурилын болон бордооны үйлдвэрийн тоног төхөөрөмж, усалгааны тоног төхөөрөмж, ойн аж ахуйн техник, тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодисыг гаалийн татвар болон НӨАТ-аас чөлөөлөх тухай хуулиуд батлагдан хэрэгжиж байсан боловч 2015 оны 7 дугаар сард гаалийн татвараас чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болгосон;
- 1.1.3. 2014 онд Импортоор оруулж байгаа ЖДҮ-ийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг гаалийн татвар болон НӨАТ-аас чөлөөлөх тухай хуулиуд батлагдан хэрэгжиж байсан боловч 2015 оны 7 дугаар сард НӨАТ-аас чөлөөлөх тухай хуулийг тус хүчингүй болгосон байна;
- 1.1.4. 2006 оны 6 дугаар сарын 16-ны өдөр шинэчлэн баталсан ХХОАТ-ын тухай хуульд заасан татвараас хөнгөлж, чөлөөлөх заалтуудад 2009-2015 оны хооронд нийтдээ 10 удаа, түүний дотор 2011 онд 2 өдрийн дотор хоёр удаа өөрчлөлт орсон;
- 1.1.5. 2006 оны 6 дугаар сарын 29-ны өдөр шинэчлэн баталсан ААНОАТ-ын тухай хуульд заасан татвараас хөнгөлж, чөлөөлөх заалтуудад 2009-2016 онд 11 удаа;
- 1.1.6. 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдөр шинэчлэн баталсан НӨАТ-ын тухай хуульд заасан татвараас хөнгөлж, чөлөөлөх заалтуудад 2015-2016 онд 2 удаа өөрчлөлт оржээ.

1.2. Тодорхой хууль, тогтоомжоор зарим барааг зарим нэр төрлийн татвараас чөлөөлөхөөр зохицуулсан байх боловч бусад хууль, тогтоомжоор тухайн бараанд ижил төстэй нөхцөлд ногдуулах татварыг чөлөөлөхгүй байхаар зохицуулжээ. Тухайлбал:

- 1.2.1. НӨАТ-ын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5-д заасан зэвсэгт хүчин, цагдаа, улсын аюулгүй байдлыг хангах, шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын хэрэгцээнд зориулан импортоор оруулж байгаа зэвсэг, тусгай техник хэрэгсэлийг;
- 1.2.2. 13.1.12-д заасан эрдэм шинжилгээ, судалгааны ажлын туршилтын бүтээгдэхүүнийг;
- 1.2.3. 13.1.22-д заасан соёлын өвийг судалж шинжлэх, сэргээн засварлахад ашиглах материал, техник, тоног төхөөрөмж, бодис, багаж хэрэгслийг НӨАТ-аас чөлөөлөхөөр тус тус заасан байхад ижил нөхцөлд дээрх барааг гаалийн татвараас чөлөөлөхгүй байх зохицуулалт үйлчилж байна.

Татвараас чөлөөлөгдөх барааг тодорхойлж өгөөгүйгээс импортолсон зарим барааны чөлөөлөлт төрөөс баримтлах бодлоготой нийцэхгүй байна

1.3. УИХ-аас 2005 онд баталсан “Оёмол сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зориулалтаар импортолж байгаа сэлбэг, түүхий эд, үндсэн болон туслах материалыг гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөх тухай” хуулиар чөлөөлөлтөд хамрагдах барааны жагсаалтыг Засгийн газраас батлах талаар заагаагүйгээс тухайн хуулийн хүрээнд импортолсон зарим бараа төрөөс баримтлах бодлоготой зөрчилдөж байна. Тухайлбал,

- 1.3.1. 2010-2015 онд дээрх хуулийн хүрээнд Буян ХХК-ийн импортолсон 404.7 мянган ам.долларын 38.9 мянган кг ноосонд ногдох 90.8 сая төгрөгийг гаалийн болон НӨАТ-аас чөлөөлсөн байна.



1.4. Импорттоор оруулсан ноосонд ногдох татварыг чөлөөлсөн нь уул уурхайн бүтээгдэхүүнээс бусад экспортын бүтээгдэхүүн, импортыг орлох экспортын бүтээгдэхүүнийг дэмжих төрийн бодлоготой нийцэхгүйгээс гадна ноосны экспортод сөргөөр нөлөөлөх эрсдэл үүсгэж байна.

1.5. Тодорхой нэр бүхий барааг татвараас чөлөөлөх хуульд чөлөөлөлтөд хамрагдах барааны жагсаалтыг Засгийн газар батлах талаар заасны дагуу Засгийн газраас чөлөөлөлтөд хамрагдах барааг ангиллын кодоор тодорхойлж өгсөн байдаг. Тухайлбал,

1.5.1. Гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөгдөх импорттоор оруулж байгаа ЖДҮ-ийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж сэлбэг хэрэгслийн жагсаалтыг Засгийн газрын 2014 оны 191 дүгээр тогтоолоор;

1.5.2. Гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөгдөх импорттоор оруулж байгаа хөдөө аж ахуйн зориулалттай шинэ трактор, комбайн, машин механизм, гурилын үйлдвэрийн болон усалгааны тоног төхөөрөмж, ойн аж ахуйн техник, тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодисын жагсаалтыг Засгийн газрын 2016 оны 197 дугаар тогтоолоор баталсан.

1.6. Гэтэл татвараас чөлөөлөх холбогдох хуульд чөлөөлөлтөд хамрагдах барааны жагсаалтыг Засгийн газар батлахаар заасан боловч Засгийн газраас чөлөөлөлтөд хамрагдах барааны жагсаалтыг өнөөдрийг хүртэл батлаагүйгээс хууль хэрэгжих нөхцөл бүрдээгүй байна. Тухайлбал:

1.6.1. "Гаалийн тариф, гаалийн татварын тухай" хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.14-д болон "Нэмэгдсэн өртгий албан татварын тухай" хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.19-д заасан инновацийн төслөөр дотоод, гадаадын зах зээлд шинэ бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулахад шаардлагатай, дотоодод үйлдвэрлэдэггүй түүхий эд, материал, урвалж бодист хамаарах бараа;

1.6.2. Гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөх тухай 2013 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуульд заасан газрын тосны бүтээгдэхүүнийг газрын тос, занар болон нүүрснээс үйлдвэрлэлийн аргаар гарган авах төслийн хүрээнд импорттоор оруулж байгаа технологийн тоног төхөөрөмж, сэлбэг болон тусгай зориулалтын барилгын материал;

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хуулиудад хууль, тогтоомжийг боловсруулах, батлуулахад баримтлах шаардлагыг мөрдөөгүй байна

1.7. Хууль санаачлагчаас татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаарх хуулийн төслийг боловсруулах, өргөн мэдүүлэх, батлахад “Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай”³ хуулийн 3 дугаар зүйл⁴, мөн “Хууль тогтоомжийн тухай” хуулийн 8 дугаар зүйлд /дээрх хуультай ижил заалт/ заасан заалтуудыг баримтлаагүй байна. Тухайлбал:

Хүснэгт №4 Татварын хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой хуулийн өөрчлөлтийн судалгаа

№	Шинэ болон шинэчлэн найруулсан хуулийн нэр	Дагаж нэмэлт өөрчлөлт орсон хуулийн нэр	Зүйл заалтын дугаар	Агуулга
1	Үнэт цаасны тухай шинэчилсэн найруулга	ААНОАТ-ын тухай	18.1.1.	ЗГ, аймаг нийслэлийн ЗД-ын болон Монгол Улсын Хөгжлийн банкны өрийн бичгийн /бонд/ хүү;
2	Газрын тосны тухай шинэчилсэн найруулга	ААНОАТ-ын тухай	18.1.2.	Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу тус улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа албан татвар төлөгчийн өөрт нь ногдох бүтээгдэхүүний борлуулалтаас олсон, энэ хуулийн 17.1, 17.2.1-т заасан орлого;
3	Ирээдүйн өв сангийн тухай	ААНОАТ-ын тухай	18.1.3	18.1.5. Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7.1.1-д заасан ногдол ашиг
4	Зээлийн батлан даалтын сангийн тухай	ААНОАТ-ын тухай	18.1.7	18.1.7.зээлийн батлан даалтын байгууллагын хуульд заасан үндсэн үйл ажиллагаанаасаа олсон орлого;
5	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай	ААНОАТ-ын тухай	18.1.8	18.1.8.байгалийн нөөцийг хэмнэлттэй ашиглах, орчны бохирдол, хаягдлыг багасгах, байгальд халгүй техник, тоног төхөөрөмжийг борлуулсан орлого.
6	Инновацийн тухай	ААНОАТ-ын тухай	18.1.9.	улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс хойш гурван жилийн хугацаанд Инновацийн тухай хуульд заасан гарааны компанийн дотоодод шинээр үйлдвэрлэсэн инновацийн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтын орлого.

³ Уг хууль нь 2011 оноос дагаж мөрдөгдсөн ба 2015 оны 5 дугаар сарын 29-нд “Хууль тогтоомжийн тухай” хууль батлагдсанаар хүчингүй болсон.

⁴ 3.1. Хууль санаачлагч нь...: 3.1.1.нийгмийн тухайн харилцааны төлөв байдал болон түүнийг зохицуулж байгаа хуулийн хэрэгжилт, үр нөлөөг судалсны үндсэн дээр уг асуудлаар шинээр хууль гаргах болон дагаж мөрдөж байгаа хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлагыг тодорхойлсон байх; 3.1.2.хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлох; 3.1.3.хуулийг хэрэгжүүлэх талаар цаашид авах-арга хэмжээний тухай санал, түүнтэй холбогдон гарах төсөв, санхүүгийн зардлын тооцоог гаргасан байх;



7	Хадгаламжийн даатгалын тухай	ААНОАТ-ын тухай	18.1.10.	хадгаламжийн даатгалын сангийн хураамжийн орлого.
8	Хөрөнгө оруулалтын тухай	ААНОАТ-ын тухай	18.1.11	хөрөнгө оруулалтын сангийн орлого
9	Чөлөөт бүсийн тухай	ААНОАТ-ын тухай	18.1.13.	чөлөөт бүсэд зориулсан эрчим хүч, дулааны эх үүсвэр, шугам сүлжээ, цэвэр усан хангамж, ариутгах татуурга, авто зам, төмөр зам, нисэх онгоцны буудал, харилцаа холбооны үндсэн сүлжээ зэрэг дэд бүтцэд 500.0 мянган америк доллар буюу түүнээс дээш хэмжээний хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн чөлөөт бүсээс олсон орлогод оруулсан хөрөнгө оруулалтын 50 хувьтай тэнцэх хэмжээний орлого;
10		ААНОАТ-ын тухай	18.1.14	Чөлөөт бүсэд агуулах, ачиж буулгах байгууламж, зочид буудал, аялал жуулчлалын цогцолбор, импортыг орлох болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахад 300.0 мянган америк доллар буюу түүнээс дээш хэмжээний хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн чөлөөт бүсээс олсон орлогод оруулсан хөрөнгө оруулалтын 50 хувьтай тэнцэх хэмжээний орлогын албан татварын хөнгөлөлт үзүүлэх
11	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай	ААНОАТ-ын тухай	19.12	тодорхой нутаг дэвсгэрийн усны нөөцийг нэмэгдүүлэх, усны найдвартай хангамжийг бүрдүүлэх зорилгоор байгалийн усны чанарыг сайжруулах, гол, горхийг нөхөн сэргээх арга хэмжээг санхүүжүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нийт орлогод ногдох албан татварыг тухайн арга хэмжээнд зарцуулсан хэмжээгээр хөнгөлнө.
12	Ирээдүйн өв сангийн тухай	НӨАТ-ын тухай	13.5.17.	Ирээдүйн өв санд улсын төсвөөс хуваарилсан орлого эх үүсвэр, сангийн хөрөнгө оруулалтын орлого.
13	Соёлын өвийг хамгаалах тухай	НӨАТ-ын тухай	13.1.22.	соёлын өвийг судалж шинжлэх, сэргээн засварлахад ашиглах материал, техник, тоног төхөөрөмж, бодис, багаж хэрэгсэл;
14	Газрын тосны тухай шинэчилсэн найруулга	НӨАТ-ын тухай болон Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай		Газрын тосны бүтээгдэхүүнийг газрын тос, занар болон нүүрснээс үйлдвэрлэлийн аргаар гарган авах төслийн хүрээнд импортоор оруулж байгаа технологийн тоног төхөөрөмж, сэлбэг болон тусгай зориулалтын барилгын материалыг НӨАТ болон ГАТ-аас чөлөөлсүгэй. /НӨАТ-ын шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан 2016.01.01-нээс хүчингүй болсон/

1.8. Хууль санаачлагч нар аливаа татварын чөлөөлөлттэй холбоотой хуулийг боловсруулахдаа нийгмийн хэрэгцээ шаардлагыг сайтар тодорхойлох, тооцоо судалгаанд үндэслэх, нэгэн зэрэг олон салбарыг хамруулж хавтгайруулахгүй, хэрэгжүүлэх арга зам нь тодорхой, хүндрэл багатай байх зарчмыг баримтлах хэрэгтэй байна.

1.9. Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5⁵, мөн Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 10¹ дүгээр зүйлийн 10^{1.1}⁶-д зааснаар Сангийн яам нь татварын бодлого, үүний дотор хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогыг тодорхойлж нэгтгэн удирдах чиг үүрэгтэй ч 2012-2016 онд нийт 29 хууль тогтоомжид оруулсан нэмэлт өөрчлөлтөөс 7 хуулийг Сангийн яам, 22 хуулийг бусад салбарын яамдын саналыг үндэслэн, хууль санаачлагчдаас боловсруулсан байна.

Татвараас чөлөөлөх тусгайлсан хуулиудыг төсвийн жилийн дундуур баталж байгаа нь төсвийн орлогыг төлөвлөсөн хэмжээгээр бүрдүүлэхэд хүндрэл учруулж байна

1.10. УИХ-аас төсвийн жилийн явцад нэр бүхий барааг татвараас чөлөөлөх тухай хуулийг баталсны улмаас улсын төсвийн татварын орлого төлөвлөсөн хэмжээнээс 2016 онд нийт дүнгээрээ 63.3 тэрбум төгрөг буюу төлөвлөснөөс⁷ 5.8 хувиар дутуу төвлөрсөн байна. Үүнд:

1.10.1. УИХ-аас 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр баталсан “Импортоор оруулж байгаа болон дотооддоо худалдан борлуулсан хөдөө аж ахуйн зориулалттай шинэ трактор, комбайн, машин механизм, гурилын болон бордооны үйлдвэрийн тоног төхөөрөмж, усалгааны тоног төхөөрөмж, ойн аж ахуйн техник, тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодисыг НӨАТ-аас чөлөөлөх тухай” хуулийн дагуу машин механизм, тоног төхөөрөмжинд ногдох 63.3 тэрбум төгрөгийн татварыг чөлөөлжээ.

1.11. УИХ-аас баталсан зарим хуулийн үйлчлэх хугацааг хууль баталсан өдрөөс 1 сараас 1 жил хүртэлх хугацаагаар ухрааж мөрдөхөөр баталжээ. Тухайлбал:

1.11.1. 2016 оны 2 дугаар сарын 04-ний өдөр баталсан “Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн импортолсон эрчим хүчийг татвараас чөлөөлөх хуулийн хэрэгжиж эхлэх хугацааг 2015 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс;

1.11.2. 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдөр баталсан “Импортоор оруулж байгаа болон дотооддоо худалдан борлуулсан ХАА-н зориулалттай шинэ трактор, комбайн, машин механизм, гурилын

⁵ “ЗГ-ын гишүүн /Сангийн сайд/ дор дурдсан хүрээний /татварын/ бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг эрхэлнэ”

⁶ Төрийн захиргааны төв байгууллагын боловсруулсан санхүү, төсөв, татварын чиглэлээр хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэгдсэн санал дүгнэлтэд хүрсний үндсэн дээр хамтран батлах;

⁷ 2016 онд НӨАТ-ын орлогоор 1,081.4 тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрөхөөр төлөвлөж баталсан.




болон бордооны үйлдвэрийн тоног төхөөрөмж, усалгааны тоног төхөөрөмж, ойн аж ахуйн техник, тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодисыг татвараас чөлөөлөх хуулийн хэрэгжиж эхлэх хугацааг 2016 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тус тус хуульчилсан байна.

1.12. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.5-д “*төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх*” гэж заасныг биелүүлээгүй байна.

Хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэрэгжиж дуусах хугацааг цаг үеийн хэрэгцээ шаардлагатай уялдуулаагүйгээс 0.4 тэрбум төгрөгийн төсвийн орлого бүрдүүлэх боломжийг алдсан байна

1.13. 2009 оны 10 сард баталсан импортоор оруулж буй томуугийн А хүрээний (H1N1) вирусын /тус өвчний дэгдэлт буурсан/ халдварын оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж, эм хэрэгслийг татвараас чөлөөлөх хуулийн хэрэгжиж дуусах хугацааг тодорхой заагаагүйгээс дээрх хуулийн хүрээнд 2015-2016 онд нийтдээ 288 удаагийн 1,402.0 мянган ам.долларын тоног төхөөрөмж, эм хэрэгсэл бүгд 0.4 тэрбум төгрөгийн татвараас чөлөөлөгджээ.

1.14. Онцгой албан татварын тухай хуулийн хүрээнд 2015-2016 онд нийт 57,267 ширхэг автомашинд ногдох 326.6 тэрбум төгрөгийн онцгой татварыг чөлөөлсөн байна.



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

1.15. Тухайн онуудад мөрдөгдөж байсан онцгой албан татварын тухай хуулиар хос тэжээлт автомашиныг үйлдвэрлэсэн он, цилиндрийн багтаамж зэргийг харгалзалгүй чөлөөлөхөөр баталснаас импортолсон хос тэжээлт автомашины 80-84 хувь нь үйлдвэрлэснээс хойш 7 ба түүнээс дээш жил ашигласан хуучин автомашин байна.

1.16. Ази-Европын Дээд түвшний 11 дүгээр уулзалт /АСЕМ 11/-ын үйлчилгээнд ашиглах зориулалтаар 2016 оны 4 дүгээр сарын 14-нөөс 8 дугаар сарын 12-ны хооронд импортоор оруулсан 228 ширхэг суудлын автомашин, микроавтобус, тусгай зориулалтын автомашин, 303 ширхэг тусгай зориулалтын тоног төхөөрөмжинд ногдох 1.2 тэрбум төгрөгийн гааль, 1.3 тэрбум төгрөгийн онцгой, 2.7 тэрбум төгрөгийн нэмэгдсэн өртгийн, нийт 5.2 тэрбум төгрөгийн албан татварыг чөлөөлжээ.

1.17. “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн 2016 онд импортолсон нийт 67.3 мянган тонн түлшийг “Олон улсын гэрээ болон Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу гаалийн болон бусад татвараас бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлж гаалийн нутаг дэвсгэрт түр оруулах горим”-оор бүрдүүлэлт хийж, дээрх түлшинд ногдох нийт 31.5 тэрбум төгрөгийн албан татвараас БНМАУ болон ЗСБНХУ-ын хооронд байгуулсан “1949 оны хэлэлцээр”-ийг үндэслэн чөлөөлжээ.

Засгийн газраас баталсан татвараас чөлөөлөх барааны жагсаалт хуулийн зорилгыг алдагдуулж салбарын үйлдвэрлэлийг бус, салбарын хэрэглээг дэмжсэн байна

1.18. ЖДҮ-ийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг татвараас чөлөөлөх тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газраас үйлдвэрлэл явуулахад ашиглагдах барааг татвараас чөлөөлөхөөр жагсаалт⁸ баталсан боловч тус жагсаалтад салбарын үйлдвэрлэлийг бус, салбарын хэрэглээг дэмжсэн барааг хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулахаар 2014 оны 191 дүгээр тогтоолоор баталжээ.

1.19. 2015-2016 онд дээрх жагсаалтын дагуу импортоор оруулсан салбарын хэрэглээг дэмжсэн 93.9 сая ам.долларын бараанд ногдох 29.5 тэрбум төгрөгийн татварыг чөлөөлсөн байна. Тухайлбал,

1.19.1. Мэдээллийн технологийн салбарын хэрэглэгчийн зориулалттай тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл буюу сүлжээний төхөөрөмж, зөөврийн компьютерийн гар, кабель утас зэрэгт ногдох 4.2 тэрбум төгрөгийн татварыг, Мэдээллийн технологийн

⁸ Засгийн газрын 2014 оны 191 дүгээр тогтоолоор 31 үйлдвэрлэлийн чиглэлээр нийт 617 нэр төрлийн тоног төхөөрөмжийг баталсан.



салбарын хэрэглэгчийн зориулалттай тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл буюу сүлжээний төхөөрөмж, зөөврийн компьютерийн гар, кабель утас зэрэгт ногдох 4.2 тэрбум төгрөгийн татварыг;

- 1.19.2. Ахуйн хэрэглээнд ашиглах зууханд ногдох 277.7 сая төгрөгийн татварыг тус тус чөлөөлжээ.

1.20. Засгийн газрын 2017 оны 168 дугаар тогтоолоор⁹ мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн жагсаалтыг шинэчлэн баталж сүлжээний төхөөрөмж, зөөврийн компьютерийн гар, кабель утас зэргийг жагсаалтаас хассан байна.

1.21. Хэрэв дээрх барааг анхнаасаа тус жагсаалтад хамруулаагүй байсан бол 2015-2016 онд улсын төсөвт 3.3 тэрбум төгрөгийн татварын орлого төвлөрөх боломжтой байсан байна.

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэрэгжилт, үр дүнд тооцоо судалгаа хийж, үнэлэлт дүгнэлт өгдөг байгууллага байхгүй байна

1.22. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэрэгцээ, шаардлага, үр нөлөө, үр дүнгийн талаар тооцоо судалгаа хийж, үнэлэлт дүгнэлт өгсөн төрийн байгууллага байхгүй байна. Тухайлбал,

- 1.22.1. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаарх хуулийн хэрэгцээ, шаардлагыг болон нийгэмд үзүүлэх эерэг болон сөрөг нөлөөллийг судлах;
- 1.22.2. Хууль, тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлж, давхардал, хийдэл, зөрчлийг арилган хуулийг хэрэглэхэд ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах;
- 1.22.3. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаарх хууль, тогтоомжийн хэрэгжилтийн явц, хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийж, үр дүнд тооцоогүй байна.

1.23. УИХ-аас 2015 онд баталсан “Хууль тогтоомжийн тухай” хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6-д “хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалыг Засгийн газар баталж мөрдүүлнэ” гэж заасны дагуу тус аргачлалыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор 2017 оноос дагаж мөрдөхөөр баталсан ба одоогоор үнэлээгүй байна.

Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслийн барааг түр горимд байршуулах хугацааг хуульд уян хатан тусгах шаардлагатай байна

1.24. Гаалийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1¹⁰-д заасны дагуу “Олон улсын гэрээ болон Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу гаалийн болон бусад татвараас бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлж гаалийн нутаг дэвсгэрт түр оруулах горим-507”-д зээл, тусламжийн шугамаар импортоор оруулсан тоног төхөөрөмж байршдаг боловч гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй ихэнх төслийн хэрэгжих хугацаа 1-ээс дээш жил үргэлжилдгээс Гаалийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1¹¹-д заасантай зөрчилдөж байна.

1.25. Тухайлбал, дээрх горимд “Олон улсын шинэ нисэх онгоцны буудал” төслийн 32.2 км хурдны замын барилгын ажил гүйцэтгэх “СТСЕ мон” ХХК-ийн 232.2 мянган ам.долларын машин механизм, тоног төхөөрөмжийн хугацаа 2-4 сараар хэтэрсэнд гаалийн байгууллагаас хяналт тавьж, барааг түр горимоос буцаан гаргахыг мэдэгдсэн боловч тухайн төслийн хэрэгжих хугацаа 2017 онд дуусахаар хүлээгдэж, тоног төхөөрөмжийг ашигласан хэвээр байгаа нь хуулийн зөрчил үүсгэж байна.

Монгол Улс олон улсын жишгээс илүү, хавтгайруулсан байдлаар хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлж байна

1.26. Монгол Улсад татварын чөлөөлөлтөд хамрагдаагүй салбар гэж бараг байхгүй байхад дэлхийн ихэнх улс оронд эрүүл мэнд, боловсрол, хөдөө аж ахуй, санхүү, нийтийн тээвэр зэрэг цөөн тооны салбарт татварын чөлөөлөлт үзүүлэхийг дэмждэг байна. Тухайлбал,

⁹ Засгийн газрын 2017 оны 168 дугаар тогтоолоор ЖДҮ-ийн үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийг татвараас чөлөөлөх тухай шинэчилсэн жагсаалтыг баталж, 2014 оны 191 дүгээр тогтоолыг хүчингүй болгосон.

¹⁰ барааг гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горимын дагуу шаардагдах бичиг баримтыг үндэслэн гадаадын бараанд өөрчлөлт оруулахгүйгээр хугацаанд нь буцаан гаргах нөхцөлөөр гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулна

¹¹ “Гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горимд байршуулсан барааг гаалийн нутаг дэвсгэрээс буцаан гаргах хугацаа нь барааг тухайн горимд байршуулсан өдрөөс хойш.. 1 жилээс дээшгүй байна.



- 1.26.1. Албани улсын тухайд орон сууцны үйлчилгээ, шуудан, дипломатын хэрэгцээнд зориулан импортолсон бүтээгдэхүүн, халаалтанд зориулсан керосин;
 - 1.26.2. Камерун улсын тухайд хөдөө аж ахуй, хүнсний бүтээгдэхүүн /сүү, гурил, бордоо г.м/, дипломатын хэрэгцээнд зориулан импортолсон бүтээгдэхүүн, ашгийн төлөө бус байгууллагын үйлчилгээ, сонин, тогтмол хэвлэл;
 - 1.26.3. БНХАУ-ын тухайд хувиараа үйлдвэрлэсэн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, шинжлэх ухааны судалгаа, туршилт, боловсролд зориулан импортолсон бүтээгдэхүүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, байгууллагын зориулалттай импортолсон бүтээгдэхүүн;
 - 1.26.4. Гана улсын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн түүнд хэрэглэгдэх түүхий эд материал, загас агнуурын хэрэгсэл, ус, ном, сонин, шуудан, дипломат, консулын хэрэгцээнд зориулан импортолсон бүтээгдэхүүн, техник тоног төхөөрөмж, барилга байгууламж;
 - 1.26.5. ОХУ-ын тухайд зарим нэг ахуйн хэрэгцээний болон импортын бараа бүтээгдэхүүн гэх зэрэг болно.
- 1.27. Цаашид олон улсын туршлагын дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг тодорхой тэргүүлэх чиглэлийн гол гол салбаруудад урт хугацаанд тогтвортой хэрэгжүүлэх замаар хөнгөлөлт, чөлөөлөлтийн үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.
- 1.28. 2016 онд ОУВС-гаас Монгол Улсын төсвийн орлогын бууралтад нөлөөлж буй гол хүчин зүйлсийн нэг нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлт гэж үзсэн бөгөөд хөнгөлөлт чөлөөлөлтийн дүнг 2019 онд 2016 оны суурь үзүүлэлтээс 10 хувиар бууруулсан байх зөвлөмжийг өгчээ.
- 1.29. Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.25-д “татварын зарлага” гэж татварын хуулиар тухайн жилд татвар төлөгчид олгох татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг хэлнэ” гэж заасан тодорхойлолтыг ОУВС болон бусад олон улсын байгууллагаас зөвлөсний дагуу эргэн харж, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэрэгжилтийн байдалд хяналт, үнэлгээ хийж байх нь зүйтэй байна.



БҮЛЭГ 2. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд тавих хяналтын тогтолцоо үр нөлөөгүй байна

Татварын чөлөөлөлтөнд тавих дотоод хяналт үр нөлөөгүй байна

2.1. 2016 онд ГЕГ-ын Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газар, Татвар орлогын газраас Улаанбаатар дахь гаалийн газрын гаалийн бүрдүүлэлтийн хөнгөлөлт, чөлөөлөлтийн горимоор хийгдсэн бүрдүүлэлтэд хамтарсан шалгалт хийж, /2015 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар/ 7 аж ахуйн нэгжийн¹² 7.7 тэрбум төгрөгийн бараанд ногдох 1.1 тэрбум төгрөгийн татварын чөлөөлөлтийг зөрчилтэй гэж үзэн, бүрдүүлэлтийн дараах шалгалтыг дахин хийж 3 аж ахуйн нэгжид¹³ 17.9 сая төгрөгийн акт тогтоож, 2 аж ахуйн нэгж¹⁴-ийг зөрчилгүй гэж үзэн, 2 аж ахуйн нэгжийн шалгалтыг зогсоосон¹⁵ байна.

2.2. Шалгалтын үр дүнд илэрсэн чөлөөлөгдөх барааны хөнгөлөлтийн болон барааны кодыг буруу мэдүүлж тайлагнах, хууль, журмыг зөрчиж татвараас чөлөөлсөн зэрэг зөрчилд холбогдох гаалийн бүрдүүлэлт хийсэн, түүнийг хянасан, зөвшөөрөл олгосон шат шатны гаалийн улсын байцаагч нарт ажлын хариуцлага тооцох, шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах зөвлөмж чиглэл огт гаргаагүй байна.

2.3. Гаалийн байгууллагын дотоод хяналт шалгалт үр нөлөөгүй байгаагаас тодорхой зөрчлүүд давтагдсаар байгаа нь аудитаар илэрлээ.

2.4. Татвараас чөлөөлөгдөх барааны кодыг татвараас чөлөөлөгдөх нөхцөлтэй өөр барааны кодоор сольж бүртгэсэнтэй холбоотой дараах зөрчлүүд гарсан. Үүнд:

Хүснэгт №5 Татвараас чөлөөлөгдсөн барааны хөнгөлөлтийн кодыг хооронд зөрүүлж бүртгэсэн жагсаалт

д/д	Чөлөөлөлтөд хамаарах барааны		Чөлөөлөлтөд хамаарахгүй барааны		Тайлбар
	нэр	код	нэр	код	
1	ЖДҮ-ийн үйлдвэрлэлийн зориулалттай бараанд хамаарах 456.5 мянган ам.долларын бараанд ногдох 138.0 сая төгрөгийн татвараас чөлөөлөх дүн	624	ХАА-н зориулалттай барааны кодоор 365.2 мянган ам.долларын бараанд ногдох 109.7 сая төгрөгийн чөлөөлөсөн татварын дүн, Оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зориулалттай барааны кодоор 26.8 мянган ам.долларын бараанд ногдох 8.0 сая төгрөгийн чөлөөлсөн татварын дүн, АСЕМ-ын үйлчилгээнд ашиглах барааны кодоор 64.5 мянган ам.долларын бараанд ногдох 20.3 сая төгрөгийн татварын чөлөөлсөн татварын дүн,	622 618 637	хөнгөлөлтийн кодыг буруу сонгож, тайлагнасан
2	ХАА-н зориулалттай бараанд хамаарах 19.6 мянган ам.долларын бараанд ногдох 6.0 сая төгрөгийн татвараас чөлөөлөх дүн	622	Тууш чиглэлийн нимгэн давхаргатай хавтан /OSB/, стандартын дагуу хийгдсэн, угсрахад бэлэн модон барилгын угсармал хийцийн кодоор оруулсан бараанд ногдох 6.0 сая төгрөгийн чөлөөлсөн татварын дүн,	626	
3	Оёмол сүлжмэл бүтээгдэхүүний бараанд хамаарах 89.2 мянган ам.долларын үнийн дүнтэй деним даавуунд ногдох 27.3 сая төгрөгийн татвараас чөлөөлөх дүн	618	ЖДҮ-ийн үйлдвэрлэлийн зориулалттай барааны кодоор оруулсан деним даавуунд ногдох 27.3 сая төгрөгийн чөлөөлсөн татварын дүн,	624	
4	Тууш чиглэлийн нимгэн давхаргатай хавтанд хамаарах 343.9 мянган ам.долларын бараанд ногдох 105.2 сая төгрөгийн татвараас чөлөөлөх дүн	626	ЖДҮ-ийн үйлдвэрлэлийн зориулалттай барааны кодоор оруулсан тууш чиглэлийн нимгэн давхаргатай хавтанд ногдох 105.2 сая төгрөгийн чөлөөлсөн татварын дүн,	624	
5	Үйлдвэрлэснээс хойш ...нэг хүртэл жилийн насжилттай шинэ автобусанд ногдох 14.1 сая төгрөгийн татвараас чөлөөлөх дүн	619	ЖДҮ-ийн үйлдвэрлэлийн зориулалттай барааны кодоор оруулсан автобусанд ногдох 105.2 сая төгрөгийн чөлөөлсөн татварын дүн,	624	
6	Зүсмэл модон материалд хамаарах 5.6 мянган ам.долларын бараанд ногдох 1.7 сая төгрөгийн татвараас чөлөөлөх дүн	613	ХАА-н зориулалттай барааны кодоор 5.6 мянган ам.долларын зүсмэл модон материалд ногдох 1.7 сая төгрөгийн чөлөөлөсөн татварын дүн	622	

¹² 1. “Нью эра тур Монгол” ХХК, 2. “Дельта холдинг” ХХК, 3. “Витсамо Фүүдс” ХХК, 4. “Зитоп” ХХК, 5. “БОЖСС” ХХК, 6. “Цэвэр түлш” ХХК, 7. “Монгол Экологийн Борлоо” ХХК

¹³ 1. “Нью эра тур Монгол” ХХК 5.8 сая төгрөг, 2. “Дельта холдинг” ХХК 9.7 сая төгрөг, 3. “Витсамо Фүүдс” ХХК 2.4 сая төгрөг

¹⁴ 1. “Зитоп” ХХК, 2. “БОЖСС” ХХК

¹⁵ 1. “Цэвэр түлш” ХХК-д шалгалт хийж эхэлсэн боловч тус компанийн үүсгэн байгуулагчдын хоорондын маргаан шүүхээр шийдвэрлэгдэж байгаа тул шалгалтыг түр зогсоосон байна, 2. “Монгол Экологийн Борлоо” ХХК. Энэ компанид Гааль, татварын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу шалгалт хийж эхэлсэн боловч Гааль, татварын ерөнхий газар татан буугдаж, шалгалтын үйл ажиллагаа зогссон байна



2.5. Татвараас чөлөөлөгдөх нөхцөл, шаардлагад нийцэхгүй нийт 31.2 мянган ам.долларын үнийн дүнтэй бараанд нийт 7.6 сая төгрөгийн албан татварын чөлөөлөлт үзүүлсэн дараах зөрчлүүдийг аудитаар илрүүлж, улсын төсөвт буцаан төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

- 2.5.1. 2016 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн хүчингүй болсон “Үйлдвэрлэснээс хойш 1 хүртэл жилийн насжилттай, шинэ троллейбус, нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний стандартын шаардлага хангасан, 24 буюу түүнээс дээш суудалтай, 45 буюу түүнээс дээш зорчигчийн багтаамжтай, үйлдвэрлэснээс хойш 1 хүртэл жилийн насжилттай шинэ автобусыг НӨАТ-аас чөлөөлөх” тухай хуулийг зөрчиж, 2016 оны 11 дүгээр сард Дани ХХК-ийн импортолсон 26.2 мянган ам.долларын үнэ бүхий автобусанд ногдох 6.4 сая төгрөгийн албан татварыг чөлөөлсөн,
- 2.5.2. Киберком ХХК-ийн 2016 онд импортолсон 5.0 мянган ам.долларын үнэ бүхий 340 ширхэг компьютерийн хулгана /мауз/-ыг Засгийн газрын 2014 оны 191 дүгээр тогтоолоор баталсан татвараас чөлөөлөх мэдээллийн технологийн зориулалттай тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн жагсаалтад байгаа зөөврийн компьютерийн гарт хамаарах кодыг ашиглан 1.2 сая төгрөгийн НӨАТ-ыг чөлөөлсөн байна.

2.6. Дээр дурьдсан зөрчлүүдэд холбогдох барааны бүрдүүлэлтийн гаалийн улсын байцаагч, хяналт шалгалтын улсын байцаагч, гаалийн улсын ахлах байцаагч нар ажил үүргээ хангалтгүй хэрэгжүүлснээс материаллаг зөрчил гэж үзэж, Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу хариуцлага тооцуулахаар албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Гаалийн байгууллага татварын чөлөөлөлтөд хамрагдсан бараанд гаалийн бүрдүүлэлтийн дараах хяналт шалгалт хийх чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлж иржээ

2.7. Гаалийн тухай хуулийн 249 дүгээр зүйлийн 249.1-д¹⁶ заасан чиг үүргийн дагуу Гаалийн байгууллага татвараас чөлөөлөгдсөн барааг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхэд хийх гаалийн бүрдүүлэлтийн дараах хяналт шалгалтыг хангалтгүй хэрэгжүүлж иржээ.

2.8. Тухайлбал, Худалдаа Хөгжлийн банкны 2016 онд импортолсон мэдээллийн технологийн тоног төхөөрөмжид ногдох нийт 67.7 сая төгрөгийн, МҮХАҮТ 2015 онд импортолсон ариутгах тоног төхөөрөмжид ногдох нийт 2.4 сая төгрөгийн, иргэн М.Тамирын 2015 онд импортоор оруулж ирсэн 2 нэр төрлийн нийт 1,735 ширхэг мэдээллийн технологийн техник хэрэгсэлд ногдох 4,0 сая төгрөгийн албан татварыг тус тус чөлөөлсөн эрсдэлтэй ажил гүйлгээг болон эдгээр барааг Засгийн газрын 2014 оны 191 дүгээр тогтоолд заасан “жижиг дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий ... ” тоног төхөөрөмж мөн эсэхийг өнөөг хүртэл нягталж, шалгаагүй байна.

2.9. Түүнчлэн Засгийн газрын хоорондын гэрээ, хэлэлцээрээр болон Засгийн газрын бус шугамаар мөн Олон улсын хамтын ажиллагааны гэрээний хүрээнд хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдсан барааг зориулалтаар нь ашиглаж байгаа эсэхэд холбогдох төрийн байгууллагуудтай хамтран хяналт шалгалт зохион байгуулах чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Татваргүй барааны дэлгүүр ажиллуулах зөвшөөрлийг олгохдоо хууль зөрчиж, сонгон шалгаруулалт явуулаагүй байна

2.10. Гаалийн тухай хуулийн 138 дугаар зүйлийн 138.3¹⁷, ГЕГ-ын даргын 2007 оны 174 дүгээр тушаалаар баталсан “Татваргүй барааны дэлгүүрийн зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох” журмын 1.2-т заасныг тус тус зөрчиж “Эй Ди Зэт” ХХК, “Паладинбюлдинг” ХХК, “Ханбүргэдэй” ХХК, “Империа дюти фрий” ХХК-иудад татваргүй барааны дэлгүүр ажиллуулах тусгай зөвшөөрлийг ГЕГ-ын дарга Б.Асралт 2017 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн А/162 дугаар тушаалаараа сонгон шалгаруулалтгүйгээр шууд олгосон байна.

2.11. Дээрх компаниудад олгосон татваргүй барааны дэлгүүр ажиллуулах зөвшөөрлийг ГЕГ-ын даргын 2017 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн А/219 дүгээр тушаалаар хүчингүй болгосон боловч уг тушаалыг Улаанбаатар хотын гаалийн газарт 2017 оны 12 дугаар сарын 8-ны өдөр ирүүлжээ.

¹⁶ Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн бүрдүүлэлт хийж, гаалийн хяналтаас гаргах зөвшөөрөл олгосны дараа гаалийн мэдүүлэг болон гаалийн бүрдүүлэлтийн бичиг баримтад өгөгдсөн мэдээллийн үнэн зөвийг нягтлан шалгах, мэдүүлэгчийн экспорт, импортын үйл ажиллагаанд гаалийн зорилгоор гаалийн байгууллага бүрдүүлэлтийн дараахь шалгалтыг явуулна.

¹⁷ 138.3.Энэ хуулийн 138.1.6-д заасан зөвшөөрлийг гаалийн удирдах төв байгууллагаас баталсан журмын дагуу сонгон шалгаруулалтын үндсэн дээр олгоно



2.12. Дээрх хугацаанд Улаанбаатар хотын гаалийн газар нь Эй Ди Зэт ХХК-иас бусад 3 аж ахуй нэгжтэй татваргүй барааны дэлгүүрийн горимын дагуу гэрээ байгуулж, үйл ажиллагаанд нь тодорхой хэмжээгээр хяналт тавьж ирсэн байна. Тухайлбал:

- 2.12.1. “Империа джюти фрий” ХХК-тай 2017 оны 8 дугаар сарын 21-ний өдөр гэрээ байгуулж, тус компани “барааг гаалийн баталгаат агуулахаас татваргүй барааны дэлгүүрт оруулах /код 742/ горим”-оор 2017 оны 8 дугаар сарын 22-нд нийт 358.2 мянган ам.долларын барааг гаалийн бүрдүүлэлт хийн татваргүй барааны дэлгүүрт татан төвлөрүүлж, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноос хойш буюу 10 дугаар сард 22.9 мянган, 11 дүгээр сард 24.9 мянган, нийт 47.8 мянган ам.долларын барааг худалдан борлуулжээ.
- 2.12.2. “Паладинбюлдинг” ХХК-тай 2017 оны 8 дугаар сарын 25-ны өдөр гэрээ байгуулж, тус компани “барааг гаалийн баталгаат агуулахаас татваргүй барааны дэлгүүрт оруулах /код 742/ горим”-оор 2017 оны 9 дүгээр сард 2 удаа нийт 51.0 мянган ам.долларын, 10 дугаар сард 18.4 мянган ам.долларын, 11 дүгээр сард 12.7 мянган ам.долларын, нийт 82.1 мянган ам.долларын барааг гаалийн бүрдүүлэлт хийн татваргүй барааны дэлгүүрт татан төвлөрүүлж, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноос хойш буюу 10 дугаар сард 35.2 мянган, 11 дүгээр сард 17.0 мянган, нийт 52.2 мянган ам.долларын барааг худалдан борлуулжээ.
- 2.12.3. “Ханбүргэдэй” ХХК-ийн байгуулсан гэрээ огноо байхгүй, тус компани “хилийн чанадаас ирсэн гадаадын барааг татваргүй барааны дэлгүүрт оруулах /код 740/ горим”-оор 10 дугаар сард 1 удаа 11 дүгээр сард 3 удаа нийт 27.2 мянган, “барааг гаалийн баталгаат агуулахаас татваргүй барааны дэлгүүрт оруулах /код 742/ горим”-оор 2017 оны 11 дүгээр сард 6.6 мянган, нийт 33.8 мянган ам.долларын барааг гаалийн бүрдүүлэлт хийн татваргүй барааны дэлгүүрт татан төвлөрүүлсэн ч дэлгүүрийн үйл ажиллагаагаа эхлүүлээгүйгээс борлуулалт хийгдээгүй байна.

2.13. Улаанбаатар хотын гаалийн газар 2017 оны 12 дугаар сарын 08-ны өдөр ГЕГ-ын даргын 2017 оны А/219 дүгээр тушаалыг албан ёсоор хүлээн авсны дараа ажлын хэсэг гарган дээрх 3 дэлгүүрт тооллого хийж, гэрээг цуцлах мэдэгдэл хүргүүлэн “Паладинбюлдинг” ХХК, “Империа джюти фрий” ХХК-ий үлдэгдэл¹⁸ барааг лацадсан байна.

2.14. Харин аудитын явцад “Ханбүргэдэй” ХХК-ний 740 кодтой горимоор оруулсан барааг гаалийн баталгаат бүсээс дотоодын хэрэглээнд зориулан оруулах /код 456/ горимоор бүрдүүлэлт хийн ногдох татварыг тооцож 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдөр нийт 11.8 сая төгрөгийн татварыг улсын төсөвт төвлөрүүлж, 742 кодтой горимын 6.6 мянган ам.долларын барааг лацаджээ.

2.15. Аудитын явцад дээрх тусгай зөвшөөрлийг олгохдоо сонгон шалгаруулалт явуулсан эсэхийг албан ёсоор баталгаажуулж, албан бичгээр хариу ирүүлэхийг хүссэн боловч ГЕГ-ын удирдлага тогтоосон хугацаанд хариу ирүүлэхээс зайлсхийсээр байна.

2.16. Аудитаар татваргүй барааны дэлгүүр ажиллуулах тусгай зөвшөөрлийг хууль зөрчиж олгосон зөрчилтэй холбогдуулж ГЕГ-ын дарга Б.Асралтад сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг Монгол Улсын Ерөнхий сайдад хүргүүлж, нэр бүхий компаниудын татваргүй барааны дэлгүүрийн горимоор оруулсан бараанд ногдох холбогдох татварыг нөхөн тооцож, улсын төсвийн орлого болгох зөвлөмжийг ГЕГ-т өгөхийн зэрэгцээ дээрх асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, шалгуулах нь зүйтэй гэж үзлээ.

Татварын байгууллагын татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд тавих хяналтын үр нөлөө хангалтгүй байна

2.17. 2016 онд ТЕГ-ын дотоод аудитыг хариуцсан нэгжээс татвар төлөгчдийн цахимаар ирүүлсэн тайланд холбогдох хуулийн дагуу хөнгөлж, чөлөөлөгдөх орлогыг үнэн зөв ангилж тайлагнасан эсэх, татварын алба зөрчилтэй тайланг дахин засч залруулсан эсэх талаар харьяа газар, хэлтэст шалгалт

¹⁸ Тооллогын актаар “Паладинбюлдинг” ХХК 6470 ам.доллар, “Империа джюти фрий” ХХК 298,149.34 ам.долларын үлдэгдэлтэй.



хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар зохих арга хэмжээ авсан боловч тодорхой зөрчлүүд давтагдан гарсаар байгаа нь аудитын явцад илэрлээ.

2.18. 2015-2016 онд татвар төлөгчдийн татварын албанд ирүүлсэн НӨАТ-ын тайланд судалгаа хийж үзэхэд 510 аж ахуйн нэгж 104.0 тэрбум төгрөгийн албан татвараас чөлөөлөгдөх борлуулалтын орлогын кодыг 120 удаа бусад чөлөөлөгдөх борлуулалтын орлогын кодоор сольж, тайлангийн мэдээллийг буруу гаргасан байна.

2.19. Дээрх зөрчлийн улмаас 2016 оны байдлаар Монгол Улсад суугаа 223 татвар төлөгч гадаадын дипломат төлөөлөгчийн газар үйл ажиллагаа явуулж байгаа мэтээр татварын тоо мэдээлэл зөрүүтэй гарч байгаагаас гадна аж ахуйн нэгжүүд албан татвараас чөлөөлөгдөх борлуулалтын орлогыг бодит бус мэдүүлсэн байх эрсдэл өндөр байна.

2.20. Иймд татвар төлөгчдийн цахимаар ирүүлсэн НӨАТ-ын тайланд нарийвчилсан хяналт шалгалт хийж, албан татвараас чөлөөлөгдсөн борлуулалтын орлогын код, мэдээллийг үнэн зөв, бодитой болгох, тайланд тусгагдсан зөрүүтэй, эрсдэлтэй мэдээллийн мөрөөр татварын давтан шалгалт хийж, зөрчлийг илрүүлэх, арилгах арга хэмжээ авах талаар албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.21. 2015-2016 онд татварын албанд татвар төлөгчдөөс цахимаар ирүүлсэн ААНОАТ-ын тайланд татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдахгүй нийт 1,383.0 сая төгрөгийн орлогыг хөнгөлөлт, чөлөөлөлтөд оруулж тайлагнасан зөрчил илэрлээ. Тухайлбал:

2.21.1. Хан-Уул дүүргийн “Баянномгон” ХХК-ийн 14.8 сая, Сүхбаатар дүүргийн “Байгалаа дээдэлэ” ХХК 112.1 сая, Багахангай дүүргийн “Махболовсруулах үйлдвэр” 58.2 сая, Сэлэнгэ аймгийн “Өгөөмөрхан тайж” ХХК 402.3 сая, “Цогтманлай” ХХК 130.8 сая, Дээд шивээ ХХК 47.2 сая, Говьсүмбэр аймгийн “Илчлэг шивээ” ХХК 146.9 сая, “Гэээгт” ХХК 90.1 сая, “Боржигин нутгийн зураг” ХХК 2.7 сая, Орхон аймгийн “Номинмакс” ХХК 7.0 сая, Дархан-Уул аймгийн “Элбэгшарын гол” ХХК 10.4 сая, “Дархан-Ус трейд” ХХК 30.3 сая, Хэнтий аймгийн “Мөнх улз” ХХК 308.5 сая, Ховд аймгийн “Баганат орд” ХХК 14.1 сая төгрөгийн татвар ногдох орлогыг татвараас чөлөөлөгдөх орлогоор тайлагнаж, татвар ногдуулах орлогоо бууруулсан тул 2015 оны тайлангаар гарсан зөрчилд ногдох нөхөн татвар, торгууль, алдангийг ногдуулж улсын орлого болгох, 2016 оны тайлангаар гарсан зөрчлийг зохих журмын дагуу залруулга хийж, үнэн зөв тайлан мэдээ гаргах талаар албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

2.22. Дээрх зөрчлүүд нь ТЕГ-ын даргын 2015 оны А/159 дүгээр тушаалаар баталсан “Татварын тайлан хүлээн авах, хянах, нэгтгэл хийх журам”-ын 2.10¹⁹, мөн журмын 4.5²⁰-д заасан үйл ажиллагааг татварын албаны татвар төлөгчидтэй харьцах газар, хэлтэс мөрдөж ажиллахгүй байгаатай холбоотой байна.

2.23. Татвар төлөгчдийн цахимаар ирүүлсэн тайланд хөнгөлөлт, чөлөөлөлт нэг бүрээрээ харагддаггүй, бөөн дүнгээр байдгаас тайлан хүлээн авч байгаа байцаагчаас тайлангийн үнэн зөв, бодитой байдалд тавих хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж байна.

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн мэдээ, тайлангийн уялдааг хангуулаагүй, олон нийтэд мэдээллийг ил тод хүргүүлээгүй байна

2.24. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг хэрэгжүүлэгч байгууллагууд хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаарх мэдээ, мэдээллийн үнэн зөв, бодитой байдлыг хангах ажил хангалтгүй, өөрчлөгдөж, залруулагдсан мэдээ мэдээллийг дахиж солилцдоггүй, ажлын уялдаа холбоо хангалтгүйгээс холбогдох мэдээлэл, тайлан буруу ташаа гарч байна. Тухайлбал:

2.24.1. Гадаад орон, олон улсын байгууллагаас олгосон буцалтгүй болон хүмүүнлэгийн тусламж, зээлийн барааны татвараас чөлөөлөгдсөн дүнгийн талаар СЯ болон ГЕГ-аас 2015-2016 онд гаргасан мэдээ хоорондоо 109.7 тэрбум төгрөгөөр зөрүүтэй байгаа нь валютын ханшийн зөрүү болон тээврийн, даатгалын зэрэг нэмэлт зардлууд бүрэн тусгагдаагүйгээс;

2.24.2. 2015 онд импортоор оруулж онцгой албан татвараас чөлөөлсөн хос тэжээлт автомашины тоог Сангийн яам 25,670 ширхэг, харин ГЕГ 26,559 ширхэг гэж

¹⁹ “Татвар төлөгчийн ... ирүүлсэн тайланд нотлох баримтуудыг хавсаргасан байх зайлшгүй шаардлагатай бөгөөд энэ нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх үндэслэл болно”

²⁰ “илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах талаар Татвар төлөгчдөд үйлдлэх нэгжийн татварын улсын /ахлах/ байцаагчаас тавьсан шаардлагыг хүлээн аваагүй бол татварын хяналт шалгалт хийх тухай дүгнэлт бичиж хариуцсан нэгжийн удирдлагад танилцуулна”



хоорондоо 889 ширхэгээр зөрүүтэй тайлан гаргасан байгаа нь өмнөх онд төсвийн төслийг боловсруулах үед ГЕГ-аас авсан мэдээллийг дахин залруулж, өөрчлөөгүйгээс;

2.24.3. 2015 онд импортоор оруулж онцгой албан татвараас чөлөөлсөн хос тэжээлт автомашины тоог Сангийн яам 25,670 ширхэг, харин ГЕГ 26,559 ширхэг гэж хоорондоо 889 ширхэгээр зөрүүтэй тайлан гаргасан байгаа нь өмнөх онд төсвийн төслийг боловсруулах үед ГЕГ-аас авсан мэдээллийг дахин залруулж, өөрчлөөгүйгээс;

2.24.4. СЯ болон ТЕГ-аас гаргасан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн 2016 оны тайлан 190.0 тэрбум төгрөгөөр зөрүүтэй байгаа нь ААНОАТ-ын тайлангийн маягтанд давхар татварын гэрээний дагуу хөнгөлсөн татварыг /үүнээс 76 хувь буюу 144.3 тэрбум төгрөг Оюутолгой ХХК/ тусгах заалт байхгүйгээс,

2.24.5. Монгол Улсад гадаад улсаас сууж байгаа 30 гаруй дипломат төлөөлөгчийн газар байдаг байхад ТЕГ-аас гаргасан НӨАТ-ын тайланд НӨАТ-ын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.23-д заасны дагуу 2015 онд 260, 2016 онд 223 дипломат төлөөлөгчийн газарт 1.0-4.8 тэрбум төгрөгийн татварын чөлөөлөлт үзүүлснээр тайлагнасан байгаа нь татвар төлөгчид татварын тайланд чөлөөлөгдөх орлогын ангилал, кодыг буруу сонгосон, түүнийг татварын байгууллага шалгаж, залруулаагүйгээс тус тус шалтгаалсан байна.

2.25. Сангийн сайдын 2015 оны 317-р тушаалаар баталсан “Гадаад улсын Засгийн газар, олон улсын байгууллагаас авсан хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламжийн барааг НӨАТ болон гаалийн албан татвараас чөлөөлөх, хөнгөлөлт үзүүлэх үйл ажиллагааг зохицуулах журам”-ын 5.4-д²¹, мөн журмын 6.4-д²²-д заасан татвараас чөлөөлөгдөх хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлийн барааны татварын бүртгэл мэдээллийн сангийн програмыг өнөөг хүртэл боловсруулаагүй төдийгүй, татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн талаарх мэдээ, тайланг олон нийтэд ил тод мэдээлдэггүй байна.

²¹ “Гааль болон НӨАТ-аас чөлөөлөгдөх барааг бүртгэх онлайн бүртгэлийн програм нийтэд ил тод байна”

²² “Гааль болон НӨАТ-аас чөлөөлөгдөх барааг бүртгэх цахим бүртгэлийн програмд байршуулан дээрх тайлан мэдээг нийтэд ил тод мэдээлнэ”



ДҮГНЭЛТ

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт гаргаж байна. Үүнд:

- Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого, зохицуулалтууд тогтворгүй, харилцан уялдаагүй, хангалтгүй, үр дүнгүй байна
- Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хуулиудад хууль тогтоомжийг боловсруулах, батлуулахад баримтлах шаардлагыг мөрдөөгүй, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэрэгжилт, үр нөлөөг үнэлж дүгнээгүй байна.
- Засгийн газраас баталсан татвараас чөлөөлөх зарим жагсаалт хуулийн зорилгыг алдагдуулж салбарын үйлдвэрлэлийг бус, салбарын хэрэглээг дэмжсэн байна.
- Татвараас чөлөөлөгдөх барааг тодорхойлж өгөөгүйгээс импортолсон зарим барааны чөлөөлөлт төрөөс баримтлах бодлоготой нийцэхгүй байна.
- Монгол Улс олон улсын жишгээс илүү, олон салбарт хавтгайруулсан байдлаар хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлж байна.
- Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг хэрэгжүүлэгч байгууллагын дотоод хяналт хангалтгүй, үр нөлөө багатайгаас татвараас чөлөөлөгдөх орлого болон барааны ангилал, кодыг буруу сонгох, холбогдох татвараас чөлөөлөхгүй орлого, барааг татвараас чөлөөлөх зэрэг зөрчлүүд давтагдан гарч байна.
- Татваргүй барааны дэлгүүр эрхлэх зөвшөөрлийг олгоходоо хууль зөрчиж, сонгон шалгаруулалт явуулаагүй байна.
- Татваргүй дэлгүүр эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон шийдвэрийг хүргүүлэхдээ хугацаа алдсанаас их хэмжээний татварыг нөхөн төлүүлэх шаардлагатай болсон байна.
- Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн нэгдсэн дүн, мэдээний сан байхгүй, тайлан мэдээ зөрүүтэй, буруу гарах, зассан мэдээ тайлангаа хоорондоо эргэж солилцож мэдээлдэггүй зэрэг зөрчлүүд гарч байгаа нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг хэрэгжүүлэгч байгууллагуудын ажлын уялдаа холбоо муу, мэдээллийн ил тод байдал хангагдаагүй байгааг харуулж байна.
- Тус аудитаар илэрсэн зарим зөрчилтэй холбогдуулан холбогдох албан тушаалтнуудад сахилгын шийтгэл ногдуулах саналыг Төрийн аудитын тухай хуульд заасныг үндэслэн²³ дээд шатны албан тушаалтанд хүргүүлж байгаа боловч энэ нь Төрийн албаны тухай хууль²⁴, Засгийн газрын 1995 оны 97 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, энэ талаар төрийн дээд шатны байгууллагад гомдол гаргах” журамд заасан хариуцлага тооцох үндэслэлтэй цаг хугацааны хувьд зөрчилдөж, хариуцлага тооцох боломжгүй нөхцөл байдал үүсэж байна.

²³ 28.1-д “... гүйцэтгэлийн аудитаар материаллаг шинжтэй зөрчил гаргасан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ”

²⁴ 26.4-д “Сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш 1 сар, зөрчил гаргаснаас хойш 6 сараас илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулж болохгүй”



ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

Монгол Улсын Ерөнхий сайдад

- Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаарх бодлогыг тогтвортой хэрэгжүүлэх арга хэмжээ авах,
- Олон жилийн өмнө батлагдсан, тодорхой цаг хугацаанд хэрэгцээ шаардлага хангаж үр өгөөжөө өгсөн, томуугийн А хүрээний (H1N1) вирусын халдварын оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж, эм хэрэгслийг импортоор оруулахад татвараас чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болгох арга хэмжээ авах,
- Гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горимд байршуулах барааны хугацааг тухайн барааны онцлогоос шалтгаалан ялгаатай тогтоож, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах арга хэмжээ авах
- УИХ-аас баталсан татвар чөлөөлөлтийн хууль бүрд чөлөөлөлтөд хамрагдах барааны жагсаалтыг баталж, хэрэгжих хугацааг тодорхойлох замаар хамрах хүрээг багасгах,
- Албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулахтай холбоотойгоор Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4-т “Сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш 1 сар, зөрчил гаргаснаас хойш 6 сараас илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулж болохгүй” гэсэн заалтыг хүчингүй болгуулах асуудлыг судалж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авах

Сангийн сайдад

- Төсвийн тухай хуульд заасан “татварын зарлага” гэсэн нэр томъёог эргэн харж, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэрэгжилтийн байдалд Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-т заасны дагуу үнэлэлт, дүгнэлт өгч байх,
- Монгол Улсын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа нийт хуулиудын хүрээнд эдлүүлсэн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн нэгдсэн дүн, мэдээний сантай болох,
- Хөнгөлөлт, чөлөөлөлтийг хэрэгжүүлэгч байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулж, гаргасан тайлан мэдээний үнэн зөв байдалд анхаарч, засварласан мэдээ тайланг эргэн мэдээлж, солилцдог байх талаар журамд тусган, хэрэгжүүлэх,
- Татваргүй барааны дэлгүүр эрхлэх үйл ажиллагаанд нарийвчилсан хяналт шалгалт хийж, зөрчил дутагдал гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцох,

Гаалийн ерөнхий газрын даргад

- Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны нэр төрөл, чөлөөлөлтийн код зэрэг мэдүүлгийн үнэн зөв байдалд тавих үе шатны хяналтыг сайжруулах,
- Татвараас чөлөөлөгдсөн барааг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхэд хийх гаалийн бүрдүүлэлтийн дараах хяналт шалгалтыг хуульд заасан чиг үүргийн дагуу хэрэгжүүлэх,
- Нэр бүхий компаниудын татваргүй барааны дэлгүүрийн горимоор оруулсан бараанд ногдох холбогдох татварыг нөхөн тооцож, улсын орлого болгох арга хэмжээ авах

Татварын ерөнхий газрын даргад

- Татвар төлөгчдөөс цахимаар ирүүлж байгаа татварын тайланд тусгасан хөнгөлөлт, чөлөөлөлтийн үнэн зөв байдалд тавих үе шатны хяналтыг сайжруулах,
- Татвар төлөгчдийн татварын тайландаа тайлагнасан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн дүнд жил бүр хяналт шалгалт хийж байх ажлыг зохион байгуулах,



Холбогдох байгууллагын санал



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2017.11.17 № 4-2/6540
танай 2017.11.06 -ны № 01/1887 -т

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОР Д.ХҮРЭЛБААТАР
ТАНАА

Тайлангийн төсөлд санал
өгөх тухай

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны 2 дугаар тогтоолын дагуу “Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого, түүний хэрэгжилт, үр дүн”-д Танай байгууллагаас хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад дараах саналыг хүргүүлж байна.

1. Монгол Улсын Ерөнхий сайдад өгч буй 3 дугаар зөвлөмжид ишилсэн Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйл нь Гуравдугаар бүлэг буюу Хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулахтай холбогдуулан хийх арга хэмжээ юм. Иймд батлагдсан хуульд жил бүр Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн дагуу үнэлэлт, дүгнэлт өгөх боломжгүй тул Ерөнхий сайдад өгч буй 3 дугаар зөвлөмж, тайлангийн 1.7.2 дахь хэсгийг хасах;

2. Санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь урт хугацааны туршид хэрэгждэг олон шат дамжлага, нөхцөлтэй, хэрэгжихгүй байх магадлал өндөртэй, эрсдэл, баталгаа гэх зэрэг олон нөхцөлтэй байдгийн улмаас банк, даатгал, үнэт цаас, санхүүгийн салбарын үйлчилгээний НӨАТ ногдох борлуулалт, худалдан авалтын хэмжээг тодорхойлоход хүндрэлтэй байдаг. Иймд санхүүгийн гүйлгээ, үйлчилгээг НӨАТ-аас чөлөөлөх нь олон улсын жишиг юм. Түүнчлэн, боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн суурь асуудлыг хөнддөг салбарын үйлчилгээг НӨАТ-аас чөлөөлөх олон улсын жишиг байдаг тул Сангийн сайдад өгч буй 1 дүгээр зөвлөмж, тайлангийн 1.8.2, 1.8.3, 1.8.4 дэх хэсгийг хасах;

3. Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.25 дахь хэсэгт заасан татварын зарлагын тодорхойлолт нь эдийн засгийн онол, олон улсын зарчимтай нийцсэн. Иймд “төсвийн татварын орлогын бууралт” гэж стандарт бус, олон улсын жишигт нийцээгүй хэлбэрээр хуульд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэж байна.

Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3-т заасны дагуу татварын зарлагыг нэр төрөл, салбар бүрээр нь төлөвлөж, төсвийн гүйцэтгэлд тусган дэлгэрэнгүй тайлагнадаг. Түүнчлэн, жил бүрийн төсвийн төсөл, танилцуулгад тухайн жилийн татварын зарлагыг нарийвчлан тооцож, төсвийн орлого тооцоход харгалзан үздэг бөгөөд салбар, нэр төрөл бүрээр Улсын Их Хурал, олон нийтэд тайлагнан мэдээлэх арга хэмжээ авдаг.

Иймд Сангийн сайдад өгч буй 2 дугаар зөвлөмж, тайлангийн 1.10.4, 1.10.5 дахь хэсгийг тус тус хасах саналтай байна.

Хүндэтгэсэн,

Ч.ХҮРЭЛБААТАР

03621



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

14193 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их тойруу 81/1, Утас: 35-00-54, Факс: (976-11) 35-00-60,
E-mail: gaali@customs.pmis.gov.mn,
http://www.customs.pmis.gov.mn

2017.11.15 № 01/4696
танай _____-ны № _____-т

Аудитын тайлангийн төсөлд
санал хүргүүлэх тухай

Танай газраас хэрэгжүүлсэн "Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого, түүний хэрэгжилт, үр дүн" гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Тайлангийн төслийн дүгнэлт хэсэг дээрх "Гаалийн байгууллагын удирдлага холбогдох хууль, тогтоомжийг зөрчсөн шийдвэр гаргасны улмаас их хэмжээний татварын авлага үүссэн байна." гэдгийг залруулах шаардлагатай. Учир нь "Улаанбаатар төмөр зам" нийгэмлэг нь авто бензин, дизелийн түлшний албан болон онцгой албан татварыг тухай бүр барагдуулж ирсэн хэдий ч 2015 онд онцгой албан татварын хувь хэмжээ 10-20 дахин үе шаттай нэмэгдэж ногдуулсан нийт татварын дүн 21.2 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд олон улсын гэрээний дагуу татвараас чөлөөлөх захиргааны акт гаргаагүй гэсэн үндэслэлээр Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргаж тодорхойгүй байдал үүсэж байсан. Хоёр улсын хувьцаа эзэмшигч нарын ээлжит хуралдаан Москва хотноо 2015 оны 11 дүгээр сарын 16-аас 20-ны өдрүүдэд болж уг маргаантай асуудлыг авч хэлэлцэн "Улаанбаатар төмөр зам" нийгэмлэгийн импортын түлшинд 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн онцгой албан татвар ногдуулахаа зогсоох болсныг Монголын тал илэрхийлж, энэ талаар тухайн үеийн Гааль, татварын ерөнхий газрын удирдлагуудад мэдэгдэж үүрэг болгосон. Ингээд Гааль, татварын ерөнхий газарт 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр болсон хоёр байгууллагын хамтарсан хуралдаанаар тус нийгэмлэгийн хэрэгцээний импортоор оруулж ирэх дизелийн түлшинд Нийслэл дэх Захиргааны хэргийн

0007257



анхан шатны шүүхийн шийдвэр эцэслэгдэх хүртэл онцгой албан татвар ногдуулахгүй гаалийн нутаг дэвсгэрт түр оруулах горимд байршуулахаар шийдвэрлэсэн. Түүнчлэн Улсын Их Хурал 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн импортоор оруулж ирэх дизелийн түлшний онцгой албан татвараас чөлөөлөх хуулийг 2016 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр баталсан байдаг. Ингээд Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүхийн 2016 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн №329 дугаар тогтоолоор дээр дурдагдсан нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон учраас нийт 31.5 тэрбум төгрөгийн татвар төлж барагдуулах тухай Гаалийн ерөнхий газрын 2016 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр хүргүүлсэн 01/1229 тоот албан бичгийн шаардлагыг тус нийгэмлэг өнөөг хүртэл биелүүлээгүй. Энэ нь БНМАУ, ЗСБНХУ-ын Засгийн газар хоорондын 1949 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хэлэлцээрийг шинэчлэн найруулах цаг үеийн хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.

2. Хууль санаачлагч нар аливаа татварын чөлөөлөлттэй холбоотой хуулийн төсөл дээр нийгмийн хэрэгцээ шаардлагыг сайтар тодорхойлох, тооцоо судалгаанд суурилах, олон салбарыг хамруулж хавтгайруулахгүй, хэрэгжүүлэх арга зам нь тодорхой, хүндрэл багатай байх зарчим баримтлах хэрэгтэй гэдгийг тайланд нэмэх нь зүйтэй. Үүнтэй холбогдуулан хэрэгжээд олон жил болсон нийгэм, эдийн засагт үр ашгаа өгөөд дууссан хуулийн заалт байхад нэн яаралтай барааны жагсаалтыг гаргаж батлуулах шаардлагатай зарим нэг татварын чөлөөлөлт хүлээгдэж байна. Жишээлбэл:

2.1 “Гаалийн тариф, гаалийн татварын тухай” хуулийн 38.1.14 дахь заалт, “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай” хуулийн 13.1.19 дахь заалт дээрх инновацийн төслөөр дотоод, гадаадын зах зээлд шинэ бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулахад шаардлагатай, дотоодод үйлдвэрлэдэггүй түүхий эд, материал, урвалж бодист хамаарах барааны жагсаалт, гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай 2013 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн хуульд заасан газрын тосны бүтээгдэхүүнийг газрын тос, занар болон нүүрснээс үйлдвэрлэлийн аргаар гарган авах төслийн хүрээнд импортоор оруулж байгаа технологийн тоног төхөөрөмж, сэлбэг болон тусгай зориулалтын барилгын материалын барааны жагсаалтыг тус тус Засгийн газар батлаагүйгээс хууль хэрэгжиж эхлээгүй байна. Энэ хэсгийг тайлангийн Бүлэг 1-ийн 1.2 заалтад нэмүүлэх.



2.2 Жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгагдсан бөгөөд уг хуулийг хэрэгжүүлэх явцад импортлогчоор ялгах, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, үйлдвэрийн салбарыг харгалзан үзэх тал дээр хүндрэл тулгардаг учраас үүнийг тодорхой нэг мөр болгох. Энэ хэсгийг тайлангийн Бүлэг 1-ийн 1.6 заалтад нэмүүлэх.

2.3 Оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зориулалтаар импортолж байгаа сэлбэг, түүхий эд, үндсэн болон туслах материалыг гаалийн албан татвараас чөлөөлөх тухай 2005 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн хууль нь хэрэгжиж эхлээд 10 гаруй жил болсон бөгөөд жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэлтэй ижил төстэй бараа байдаг учраас давхардлыг арилгаж Засгийн газраар батлуулах. Энэ хэсгийг тайлангийн Бүлэг 1-ийн 1.2.2 заалтад нэмүүлэх.

2.4 Атрын III аяны хүрээнд батлагдсан хөдөө аж ахуйн зориулалттай шинэ трактор, комбайн, машин механизм, гурилын үйлдвэрийн болон усалгааны тоног төхөөрөмж, ойн аж ахуйн техник тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодисыг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн үйлчлэх хугацаа 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгагдсан бөгөөд хэрэгжиж эхлээд 10 орчим жил болж үр ашгаа өгсөн гэж үзэх үндэслэлтэй тул боломжтой бол хүчингүй болгох. Энэ хэсгийг Бүлэг 1-ийн 1.5 заалт нэмүүлэх.

Иймд эдгээр үндэслэлүүдийг харгалзан үзэж аудитын тайлангийн төсөлд тусгах нь зүйтэй гэж үзэж байна.

ДАРГА  БАСРАЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн Үндэстний гудамж, Утас/Факс: (976-11) 32-76-86,
E-mail: info@mta.mn

2014.11.15 № 01/3204

танай _____ -ны № _____ -т

Тайлбар хүргүүлэх тухай

Үндэсний аудитын газраас ирүүлсэн "Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого, түүний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад дараах тайлбарыг хүргүүлж байна. Үүнд:

Тайлангийн төслийн 2 дугаар бүлгийн 2.4.5 дах заалт:

1. ААНОАТ-ын 2015 оны тайлангаар татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдахгүй байх магадлалтай "Цогтманлай" ХХК, "Дээд шивээ" ХХК, "Мөнх Улз" ХХК-ыг татварын хяналт шалгалтад хамруулж, 486.5 сая төгрөгийн зөрчлийг тодорхойлсоны үндсэн дээр залруулга хийх боломжтой юм.


2. ТЕГ-ын даргын 2017 оны А/05 дугаар тушаалаар баталсан "Татварын тайлан хүлээх авах, хянах, нэгтгэл хийх журам"-ын 5 дугаар зүйлийн 5.2 дах заалтад "Сар улирал, жилийн эцсийн тайланд хийх залруулгыг дараа оны 12 дугаар сарын 31-нийг хүртэл хугацаанд харьяалагдах татварын албанд залруулга хийнэ" гэж заасны дагуу Сэлэнгэ, Говьсүмбэр, Дархан-Уул аймаг, Чингэлтэй дүүргийн татварын хэлтэстэй харилцагч "Өгөөмөрхан тайж", "Элбэгшарын гол", Дархан-Ус трейд", "Гээзгт", "Боржигон нутгийн зураг" зэрэг ХХК-уудын 535.8 сая төгрөгийн хөнгөлөлт, чөлөөлөлтийн орлогыг татвар төлөгчийн хүсэлтээр залруулсан болно.

3. "Баянномгон", "Байгалаа дээдэлъе", "Махболовсруулах үйлдвэр", "Илчлэг шивээ", "Номинмакс", "Баганат орд" зэрэг ХХК-тай холбогдон ТЕГ-ын 2017 оны А/05 дугаар тушаалаар баталсан "Татварын тайлан хүлээх авах, хянах, нэгтгэл хийх журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.4 дэх заалт "ТЦМС-д хүлээн авсан тайланд орлого, татварын ногдлоо буруу тодорхойлсон болон тооцооллын талаар зөрчил илэрсэн бол татвар төлөгчөөр өөрөөр нь засуулах арга хэмжээ авна" гэж заасны дагуу тайлангаа залруулах талаар мэдэгдсэн болно.

Тайлангийн төслийн 2 дугаар бүлгийн 2.5.1.5 дах заалт:

Цахим төлбөрийн баримтын системд борлууллагч тал нь НӨАТ-ын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.23 дах заалтын дагуу чөлөөлөлт эдлэх код /303/-ийг ашиглаж байсныг илрүүлэн, 2017 оны 06 дугаар сард ГТМТТ-д албан бичгээр хүргүүлж зөрчлийг арилган, засварлуулсан болно.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д. ЗАНДАНБАТ

2017 alban toot



Ирүүлсэн саналд өгөх тайлбар

Сангийн яамнаас ирүүлсэн саналд дараах тайлбарыг өгч байна.

1. Ирүүлсэн саналын хүлээн авч, Сангийн сайдад татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэрэгжилтийн байдалд Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-т заасны дагуу үнэлэлт, дүгнэлт өгч байх зөвлөмжийг өгч найрууллаа.

Харин тайлангийн 1.7.2 дахь хэсэгт заасан “хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал” нь хууль, тогтоомжийн төсөл боловсруулахад хамаарахгүй тул үүнийг хасах саналыг хүлээж авах боломжгүй байна.

2. Ирүүлсэн санал, тайлбарыг хүлээн авч тайланд тусгасан болно.

3. Ирүүлсэн санал, тайлбарыг хүлээн авч тайлангийн 1.10.4 болон 1.10.5 дахь өгүүлбэрийг нэгтгэн “Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.25-д “татварын зарлага” гэж татварын хуулиар тухайн жилд татвар төлөгчид олгох татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг хэлнэ” гэж заасан тодорхойлолтыг ОУВС болон бусад олон улсын байгууллагаас зөвлөсний дагуу эргэн харж, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэрэгжилтийн байдалд хяналт, үнэлгээ хийж байх нь зүйтэй” гэж найрууллаа.

Гаалийн ерөнхий газраас ирүүлсэн саналд дараах тайлбарыг өгч байна.

1. Ирүүлсэн санал болон УБТЗ Хувь Нийлүүлсэн Нийгэмлэгийн удирдлагуудаас ирүүлсэн тайлбар, нэмэлт нотлох баримтуудыг үндэслэн тайлангийн 1.5.5-д найруулан өөрчилж орууллаа.

2. Саналыг хүлээн авч, холбогдох асуудлыг тайлангийн 1.3.2-д нэмж тусгасан болно.

3. Ирүүлсэн саналын 2.1-ийг хүлээн авч, тайлангийн 1.2.2-д нэмж тусгасан болно.

4. Жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг холбогдох татвараас чөлөөлөх хууль нь үйлдвэрлэлийн зориулалттай гэж тодорхой заасан тул саналын 2.2-ыг хүлээн авах боломжгүй байна.

5. Гаалийн албан татвараас чөлөөлөх хуулиар оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зориулалтаар импортолж байгаа сэлбэг, түүхий эд, үндсэн болон туслах материалыг, харин импортоор оруулж байгаа жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж сэлбэг хэрэгслийг татвараас чөлөөлөх хуулийн дагуу Засгийн газраас баталсан жагсаалтад оёдол сүлжмэлийн үйлдвэрийн зориулалттай машин тоног төхөөрөмжүүдийг татвараас чөлөөлж байгаа тул саналын 2.3-ыг хүлээн авах боломжгүй байна.

6. Засгийн газрын 2016 оны 12 дугаар сард баталсан 212 дугаар тогтоолоор “Атрын III аян”-ыг 2017 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн үргэлжлүүлэхээр заасан тул саналын 2.4-ийг хүлээн авах боломжгүй байна.

Татварын ерөнхий газраас ирүүлсэн тайлбар:

1. Тайлангийн төсөлд тус газраас санал ирээгүй, харин тайлангийн төсөлд дурьдсан зөрчилд тайлбар ирүүлсэн тул тайлбартай танилцаж, тайлангийн 2.3.5.1-ийг өөрчлөн найруулсан болно.



Хавсралт

Аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт

Илэрсэн зөрчил	Тухайн үед хариуцаж байсан албан тушаалтан	Аудитаар авсан арга хэмжээ
Сонгон шалгаруулалтгүйгээр нэр бүхий компаниудад татваргүй барааны дэлгүүр ажиллуулах зөвшөөрлийг шууд олгосон,	ГЕГ-ын дарга Б.Асралт	Илэрсэн зөрчилтэй асуудлыг Хууль, хяналтын байгууллагад шилжүүлж, шалгуулахаар шийдвэрлэсэн.
ГЕГ-ын дарга Б.Асралт нь Гаалийн тухай хуулийг зөрчин сонгон шалгаруулалтгүйгээр нэр бүхий 4 компанид зөвшөөрөл олгосон, дээрх зөвшөөрлийг ГЕГ-ын даргын тушаалаар цуцалсан боловч тус шийдвэрийг 2 сарын дараа УБ хотын гаалийн газарт хүргүүлснээр нэр бүхий компаниудын энэ хугацаанд борлуулсан барааны борлуулалтад ногдох холбогдох татварыг улсын төсөвт төвлөрүүлэх боломжийг алдсан,	ГЕГ-ын дарга Б.Асралт	ГЕГ-ын дарга Б.Асралтад сахилгын шийтгэл ногдуулах арга хэмжээ авах албан шаардлагыг Ерөнхий сайдад хүргүүлэхээр, нэр бүхий компаниудын татваргүй барааны дэлгүүрийн горимоор оруулсан бараанд ногдох холбогдох татварыг нөхөн тооцож, улсын орлого болгох зөвлөмжийг ГЕГ-т өгөхөөр шийдвэрлэсэн.
Татвараас чөлөөлөгдөх нөхцөл, шаардлагад нийцэхгүй бараанд ногдох 7.6 сая төгрөгийн албан татварыг чөлөөлсөн,	Дээрх зөрчлүүдэд холбогдох давхардсан тоогоор 75 мэдүүлэгт нэр бүхий 33 бичиг баримтын гаалийн улсын байцаагч, 38 хяналт шалгалтын гаалийн улсын байцаагч, 31 гаалийн улсын ахлах байцаагч	Холбогдох 33 бичиг баримтын гаалийн улсын байцаагч, 38 хяналт шалгалтын улсын байцаагч, 31 улсын ахлах байцаагчид хариуцлага тооцох албан шаардлагыг ГЕГ-ын даргад өгөхөөр шийдвэрлэсэн.
Татвараас чөлөөлөгдөх 292.3 сая төгрөгийн барааны кодыг татвараас чөлөөлөгдөх нөхцөлтэй өөр барааны кодоор сольж мэдүүлсэн,		
Татвараас чөлөөлөгдсөн барааг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхэд хийх гаалийн бүрдүүлэлтийн дараах хяналт шалгалтыг хангалтгүй хэрэгжүүлсэн,		
Засгийн газрын хоорондын гэрээ, хэлэлцээрээр болон Засгийн газрын бус шугамаар, мөн Олон улсын хамтын ажиллагааны гэрээний хүрээнд хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдсан барааг зориулалтаар нь ашиглаж байгаа эсэхэд холбогдох төрийн байгууллагуудтай хамтран хяналт шалгалт зохион байгуулах чиг үүргээ хэрэгжүүлээгүй.	ГЕГ-ын Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газар /дарга Д.Жаргалсайхан/, ГЕГ-ын татварын орлогын газар /дарга Я.Эрдэнэчимэг/ ГЕГ-ын татварын орлогын газар /дарга Я.Эрдэнэчимэг/ гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалтын газар /дарга Д.Жаргалсайхан/	ГЕГ-т зөвлөмж өгөхөөр шийдвэрлэсэн.
2015-2016 онд татвар төлөгчдийн татварын албанд ирүүлсэн НӨАТ-ын тайланд хийсэн түүвэрлэлтээр 510 аж ахуйн нэгж 104.0 тэрбум төгрөгийн албан татвараас чөлөөлөгдөх борлуулалтын орлогын кодыг 120 удаа бусад чөлөөлөгдөх борлуулалтын орлогын кодоор сольж, тайлангийн мэдээллийг буруу гаргасан, мөн ААНОАТ-ын тайланд татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдахгүй нийт 1,383.0 сая төгрөгийн орлогыг хөнгөлөлт, чөлөөлөлтөд оруулж тайлагнасан,	ТЕГ-ын болон харьяа газар, хэлтэс, тасгийн Татвар төлөгчтэй харьцах газар /хэлтэс, тасаг/-ын дарга, татварын улсын ахлах байцаагч, татварын улсын байцаагч	



Татвараас чөлөөлөгдөх нөхцөл, шаардлагад нийцэхгүй нийт 26.2 мянган ам.долларын үнийн дүнтэй бараанд ногдох 6.4 сая төгрөгийн албан татварын чөлөөлөлт үзүүлсэн,	Холбогдох гаалийн газрын гаалийн улсын байцаагч	Чөлөөлсөн албан татварыг нөхөн төлүүлэхээр акт тогтоохоор шийдвэрлэсэн.
Татвараас чөлөөлөгдөх нөхцөл, шаардлагад нийцэхгүй нийт 5.0 мянган ам.долларын үнийн дүнтэй бараанд ногдох 1.2 сая төгрөгийн албан татварын чөлөөлөлт үзүүлсэн	Холбогдох гаалийн газрын гаалийн улсын байцаагч	Чөлөөлсөн албан татварыг нөхөн төлүүлэхээр акт тогтоохоор шийдвэрлэсэн.
Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг хэрэгжүүлэгч байгууллагууд хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаарх мэдээ, мэдээллийн үнэн зөв, бодитой байдлыг хангах ажил хангалтгүй, өөрчлөгдөж, залруулагдсан мэдээ мэдээллийг дахиж солилцдоггүй, ажлын уялдаа холбоо хангалтгүйгээс холбогдох мэдээлэл, тайлан буруу ташаа гарч байна	Сангийн яам, Гаалийн Ерөнхий газар, Татварын Ерөнхий газрын холбогдох газар, мэргэжилтнүүд	Зөвлөмж өгөхөөр шийдвэрлэсэн.



Монгол Улсын Ерөнхий аудиторовн тушаал



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2018 оны 03 сарын 02 өдөр

Дугаар А/46

Улаанбаатар хот

Г Аудитын тайланг баталгаажуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.7 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.3.3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2016 оны А/92 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.39 дэх заалт, мөн 2003 оны 53 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого, түүний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, тус аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хороо, Сангийн яам, Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газарт тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2019 оны нэгдүгээр улиралд Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Сангийн сайд /Ч.Хүрэлбаатар/, Гаалийн ерөнхий газрын дарга /Б.Асралт/, Татварын ерөнхий газрын дарга /Д.Занданбат/ нарт зөвлөсүгэй.

4. Аудитаар илэрсэн зөрчилтэй асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газар /М.Давааням/-т даалгасугай.

5. Аудиттай холбоотой ажлын болон нотлох баримтыг тайлан баталгаажсанаас хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивт хүлээлгэн өгөхийг аудитын баг /Д.Гандолгор/-т үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Tushaal\2018\0302GAG7.Docx

070315



Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны
3 дугаар сарын 02-ны өдрийн 9/46 Дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагын жагсаалт

/сая.төг/

№	Хариуцагч байгууллага	Зөрчлийн товч утга	Албан шаардлагын дугаар	Зөрчлийн дүн	Актны дугаар	Зөрчлийн дүн
1	Монгол Улсын Ерөнхий сайд	ГЕГ-ын дарга Б.Асралт нь Гаалийн тухай хуулийг зөрчин сонгон шалгаруулалтгүйгээр нэр бүхий компаниудад татваргүй барааны дэлгүүр ажиллуулах тусгай зөвшөөрлийг олгосон, хүчингүй болгосон шийдвэрийг холбогдох байгууллагад тухай бүрд нь хүргүүлээгүйгээс улсын төсөвт төвлөрөх орлогын боломжийг алдуулсан	01/84-YAГ-ГАГ/2017/10-ГА	-		
2	Гаалийн ерөнхий газар	Татвараас чөлөөлөгдөх нөхцөл, шаардлагад нийцэхгүй бараанд ногдох албан татварыг чөлөөлсөн, татвараас чөлөөлөгдөх барааны кодыг хооронд нь зөрүүлж мэдүүлсэн, хяналтыг хангалтгүй хэрэгжүүлж ажлын хариуцлага алдсан	01/112-YAГ-ГАГ/2017/10-ГА	-		
3	Гаалийн ерөнхий газар	Татвараас чөлөөлөгдөх нөхцөл, шаардлагад нийцэхгүй нийт 26.2 мянган ам.долларын үнийн дүнтэй бараанд ногдох албан татварын чөлөөлөлт үзүүлсэн			01/39-YAГ-ГАГ/2017/10-ГА	6.4
4	Гаалийн ерөнхий газар	Татвараас чөлөөлөгдөх нөхцөл, шаардлагад нийцэхгүй нийт 5.0 мянган ам.долларын үнийн дүнтэй бараанд ногдох албан татварын чөлөөлөлт үзүүлсэн			01/38-YAГ-ГАГ/2017/10-ГА	1.2
5	Татварын ерөнхий газар	Татвар төлөгчдийн цахимаар ирүүлсэн 2015, 2016 оны НӨАТ-ын болон ААНОАТ-ын тайлангаар татвараас чөлөөлөгдөх борлуулалтын орлогын кодыг чөлөөлөгдөх орлогын өөр кодоор зөрүүлж тайлагнасан, татвар ногдох орлогоос чөлөөлөгдөхгүй орлогыг чөлөөлж тайлагнасан, татварын алба хяналтыг хангалттай хэрэгжүүлээгүй	01/115-YAГ-ГАГ/2017/10-ГА	1,383.0		
Нийт дүн				1,383.0		7.6

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of multiple horizontal rows, each defined by two parallel dashed lines. The lines are evenly spaced and extend across the entire width of the page, providing a guide for letter height and placement. There is no text or other markings on the page.

[illegible]